



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО

ГЭМТ ХЭРЭГТ ХОХИРОХ ЭРСДЭЛИЙН СУДАЛГАА

2023



Улаанбаатар хот, 2024 он



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО

ГЭМТ ХЭРЭГТ ХОХИРОХ ЭРСДЭЛИЙН СУДАЛГАА

Улаанбаатар хот, 2024 он

Тайлан хянасан

Б.Батдаваа, ҮСХ-ны дарга

М.Оюунцэцэг, ҮСХ-ны Нийгмийн статистикийн газрын дарга

Д.Даваажаргал, ҮСХ-ны Нийгмийн статистикийн газрын Нийгмийн статистикийн хэлтсийн дарга

Ш.Чулуунбат, Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгааны зөвлөх

Тайлан боловсруулсан

Т.Хишигзаяа, ҮСХ-ны Нийгмийн статистикийн газрын Нийгмийн статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Г.Мөнхсүвд, ҮСХ-ны Нийгмийн статистикийн газрын Нийгмийн статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Б.Энхзул, ҮСХ-ны Нийгмийн статистикийн газрын Нийгмийн статистикийн хэлтсийн гэрээт ажилтан

Б.Лхагважав, ҮСХ-ны Нийгмийн статистикийн газрын Нийгмийн статистикийн хэлтсийн гэрээт ажилтан

Л.Хануй, Хэвлэлийн дизайнер

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Засгийн газрын III байр, 14200, 8-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар, Монгол Улс

Холбоо барих:

Утас: 1900-1212

Факс: (976-11)-321433

Цахим шуудан: information@nso.mn

Веб сайт: www.1212.mn

ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ	5
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	6
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	7
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	9
СУДАЛГААНЫ ТОЙМ	12
1. ТАНИЛЦУУЛГА	21
2. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ	22
2.1 Түүврийн арга зүй	22
2.2 Судалгааны мэдээлэл цуглуулалтад ашигласан арга	26
3. СУДАЛГААНЫ ҮНДСЭН ҮР ДҮН	28
3.1 Судалгаанд хамрагдсан өрх, хүн амын ерөнхий шинж байдал	28
3.2 Гэмт хэрэгт хохирох эрсдэл	34
3.2.1 Амьдрах орчны нөхцөл байдал	35
3.2.2 Иргэд хоорондын харилцаа, иргэдийн цагдаагийн байгууллагад итгэх итгэл	41
3.2.3 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай иргэдийн үзэл бодол	46
3.2.4 Гэмт хэргийн хохирогч болох айдас	49
3.3 Гэмт хэрэгт хохирсон байдал	53
3.3.1 Хулгайлах гэмт хэрэгт хохирсон байдал	68
3.3.2 Мал хулгайлах гэмт хэрэгт хохирсон байдал	72
3.3.3 Хүчирхийллийн улмаас хохирсон байдал	75
3.3.4 Ялгаварлан гадуурхах гэмт хэрэгт хохирсон байдал	80
3.4 Тогтвортой хөгжлийн зорилго	85

4. ХАВСРАЛТ	89
4.1 Статистик хүснэгт	90
4.2 Судалгааны мэдээлэл цуглуулалтад ажилласан баг бүрэлдэхүүн	154
4.2.1 Судалгааны удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн	154
4.2.2 Судалгааны ажлын хэсгийн бүрэлдэхүүн	155
4.2.3 Судалгааг зохион байгуулсан үндсэн багийн бүрэлдэхүүн	156
4.2.4 Судалгааны мэдээлэл цуглуулалтын ажилтнуудад зориулсан сургалтанд хичээл заасан багш нар	156
4.2.5 Судалгааны мэдээлэл цуглуулалтын багийн гишүүд	157
4.3 Нэр томьёоны товч толь: Ойлголт, тодорхойлолт	158


ӨМНӨХ ҮГ

Статистикийн тухай хуульд заасны дагуу “Гэмт хэрэгт хохирох эрсдэл”-ийн судалгааг Үндэсний статистикийн хороо Монгол Улсад анх удаа зохион байгуулж, үр дүнг хэрэглэгч Та бүхэнд хүргэж байна.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1985 оны 11 дүгээр сарын 29-ний 40/34 дүгээр тогтоолоор “Гэмт хэргийн болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирсон хохирогчдын талаарх хууль цаазын үндсэн зарчмын тухай тунхаглал” батлагдсан. Ингэснээр дэлхийн улс орнууд өөрийн онцлогт тохирсон гэмт хэргийн хохирогч судлах бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх үндэс тавигдсан. Энэхүү судалгаа нь Монгол Улсын Үндсэн хуульд тусгасан иргэний амьд явах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдлоос хамгаалуулах эрх, эрх чөлөөний байдал буюу гэмт хэрэгт хохирох эрсдэл болон хохирсон байдлыг судлах зорилготой юм. Цаашид гэмт хэргээс хохирох эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх бодлогыг боловсруулахад энэ судалгаа үнэтэй хувь нэмэр болно гэдэгт итгэлтэй байна.

Энэхүү судалгааг зохион байгуулахад арга зүйн туслалцаа үзүүлсэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Гэмт Хэрэг, Мансууруулах Бодистой Тэмцэх Газар, судалгааг нэгдсэн удирдлагаар ханган ажилласан Удирдах зөвлөл болон Ажлын хэсэг, багийн гишүүд, үндэсний зөвлөх, мэдээлэл цуглуулалтын ажлыг орон нутагт зохион байгуулсан аймаг, нийслэлийн статистикийн байгууллагын албан хаагчид, мэдээлэл цуглуулагчид болон судалгаанд хамрагдсан нийт өрхүүдэд талархал илэрхийлж, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН
ХОРООНЫ ДАРГА



Б.БАТДАВАА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ГХХЭС	Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгаа
АОАБС	Амьдрах орчны аюулгүй байдлын судалгаа
ГХМБТГ	Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газар
ГХСОУА	Гэмт хэргийн статистикийн олон улсын ангилал
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
УИХ	Улсын Их Хурал
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ТАШН	Түүврийн анхан шатны нэгж

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Судалгаанд хамрагдсан өрхийн тоо, стандарт алдаа, бүсээр	24
Хүснэгт 2.	Судалгаанд хамрагдсан өрхийн тоо, бүс, аймаг, дүүрэг, суурьшлаар	24
Хүснэгт 3.	Өрхийн сууцны төрөл, бүс, байршлаар, дүнд эзлэх хувиар	30
Хүснэгт 4.	Өрхийн сууцны эзэмшлийн хэлбэр, байршлаар, дүнд эзлэх хувиар	31
Хүснэгт 5.	Оршин сууж байгаа газрын нөхцөл байдал, бүс, байршлаар, сууцны төрлөөр, хувиар	39
Хүснэгт 6.	Уул уурхайн олборлолт, эрдэс бодисын үйлдвэр болон хүнд үйлдвэрлэлийн улмаас оршин сууж байгаа газрын байгаль, экологийн тэнцвэрт байдал алдагдсан эсэх, бүс, байршлаар, дүнд эзлэх хувиар	40
Хүснэгт 7.	Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн үзэл бодол, байршлаар, хувиар	43
Хүснэгт 8.	Гэмт хэргийн гаралтын өөрчлөлтийн талаарх иргэдийн төсөөлөл, хувиар	45
Хүснэгт 9.	Үдэш, шөнийн цагаар гэртээ ганцаараа байхад аюулгүй санагддаг эсэх, хүйс, байршлаар, сууцны төрөл, хувиар	46
Хүснэгт 10.	Өөрийгөө хамгаалах зорилго бүхий урьдчилан сэргийлэх үйлдэл, хүйс, боловсролын түвшин, байршлаар	52
Хүснэгт 11.	Сүүлийн 12 сарын хугацаанд гэмт хэрэгт өртөж хохирсон хүн амын хувь, бүс, байршлаар, гэмт хэргийн төрлөөр	58
Хүснэгт 12.	Сүүлийн 12 сард үйлдэгдсэн гэмт хэрэг улирлаар, хувиар	63
Хүснэгт 13.	Сүүлийн 12 сард үйлдэгдсэн гэмт хэрэг, хугацаагаар, хувиар	64
Хүснэгт 14.	Согтуу, мансуурсан үедээ гэмт хэрэг үйлдсэн болон хохирсон байдал, хувиар	66
Хүснэгт 15.	Гэмт хэрэг үйлдэгдсэн байршилд хяналтын камер байсан хувь, сүүлийн 3 жилээр	66

Хүснэгт 16.	Гэмт хэрэгт өртөх үед гэмт этгээд зэвсгийн шинжтэй зүйл хэрэглэсэн эсвэл хэрэглэхээр заналхийлсэн байдал, хувиар	67
Хүснэгт 17.	Гэмт хэрэг үйлдэх үед гэмт этгээдийн хэрэглэсэн зэвсгийн шинжтэй зүйл, хувиар	67
Хүснэгт 18.	Сүүлийн 3 жилд болон сүүлийн 12 сарын хугацаанд хулгайлах гэмт хэрэгт хохирсон байдал, сонгосон үзүүлэлт, дүнд эзлэх хувиар	68
Хүснэгт 19.	Сүүлийн 3 жилд болон сүүлийн 12 сарын хугацаанд мал хулгайлах гэмт хэрэгт өртөж хохирсон хохирогчийн байдал, бүс, байршлаар, дүнд эзлэх хувиар	73
Хүснэгт 20.	Сүүлийн 3 жилд болон сүүлийн 12 сарын хугацаанд хүчирхийллийн улмаас хохирсон байдал, сонгосон үзүүлэлт, дүнд эзлэх хувиар	75
Хүснэгт 21.	Сүүлийн 3 жилд болон сүүлийн 12 сарын хугацаанд ялгаварлан гадуурхах гэмт хэрэгт хохирсон байдал, сонгосон үзүүлэлт, хувиар	81

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.	Ам бүлийн байдал, дүнд эзлэх хувиар	28
Зураг 2.	Өрхийн сууцны төрөл, дүнд эзлэх хувиар	29
Зураг 3.	Өрхийн сууцны эзэмшлийн хэлбэр, дүнд эзлэх хувиар	30
Зураг 4.	Үйлдлийн чадварын хүндрэлтэй хүн ам, насны бүлэг, хүйсээр, хувиар	31
Зураг 5.	Гэрлэлтийн байдал, хувиар	32
Зураг 6.	Хүн амын боловсролын түвшин, хүйсээр, хувиар	32
Зураг 7.	Өрхийн сарын дундаж орлого (судалгаанд хамрагдахаас өмнөх 12 сарын дундаж), бүс, байршлаар, дүнд эзлэх хувиар	33
Зураг 8.	Амьдрах орчны таатай нөхцөл байдал, байршлаар	36
Зураг 9.	Амьдрах орчны таатай нөхцөл байдал, хувиар	36
Зураг 10.	Амьдрах орчны таатай нөхцөл байдал, сууцны төрлөөр, хувиар	37
Зураг 11.	Малын бэлчээрийн даацын нөхцөл байдал, байршлаар, хувиар	41
Зураг 12.	Малын бэлчээрийн даацын нөхцөл байдал, бүсээр, хувиар	41
Зураг 13.	Хөрш болон саахалтын айлын хүмүүсээ сайн мэддэг эсэх, сууцны төрөл, байршлаар, хувиар	42
Зураг 14.	Хөршийн сайн харилцаа, сууцны төрөл, байршлаар, хувиар	43
Зураг 15.	Гэмт хэргийн гаралт өсөх шалтгаан, улсын болон оршин сууж буй нутаг дэвсгэрийн хэмжээнд, хувиар	45
Зураг 16.	Сургуулийн орчинд аюулгүй санагддаг эсэх, байршлаар, хувиар	47
Зураг 17.	Сургуулийн орчинд аюулгүй санагддаг эсэх, насны бүлгээр, хувиар	48
Зураг 18.	Олон нийтийн газар аюулгүй санагддаг эсэх, байршлаар, хувиар	48
Зураг 19.	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт өртөнө гэж айдаг хүн ам, хувиар	49
Зураг 20.	Хүчирхийллийн шинжтэй үйлдэлтэй холбоотой айдас, дүнд эзлэх хувиар	50
Зураг 21.	Бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой айдас, хүйсээр, хувиар	50
Зураг 22.	Бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой айдас, байршлаар, хувиар	51
Зураг 23.	Иргэдийн өдөр тутмын амьдралын хэв маяг, хүйсээр, хувиар	53
Зураг 24.	Сүүлийн 3 жилийн хугацаанд хохирсон хүний тоо, гэмт хэргийн төрлөөр, хувиар	55
Зураг 25.	Сүүлийн 12 сарын хугацаанд гэмт хэрэгт хохисон хүний тоо, гэмт хэргийн төрлөөр, хувиар	55

Зураг 26.	Сүүлийн 3 жилд үйлдэгдсэн гэмт хэргийн тоо, тохиолдлын тоогоор, хувиар	56
Зураг 27.	Сүүлийн 12 сарын хугацаанд үйлдэгдсэн гэмт хэргийн тоо, тохиолдлын тоогоор, хувиар	56
Зураг 28.	Сүүлийн 3 жилийн хугацаанд хамгийн багадаа нэг гэмт хэргийн хохирогч болсон байдал, хүйсээр, хувиар	57
Зураг 29.	Сүүлийн 12 сарын хугацаанд хамгийн багадаа нэг гэмт хэргийн хохирогч болсон байдал, хүйсээр, хувиар	57
Зураг 30.	Сүүлийн 3 жилийн хугацаанд гэмт хэргийн талаар холбогдох эрх бүхий байгууллагад мэдэгдсэн эсэх, бүс, байршлаар, хувиар	59
Зураг 31.	Сүүлийн 3 жилийн хугацаанд гэмт хэргийн талаар эрх бүхий байгууллагад мэдэгдсэн байдал, гэмт хэргийн төрлөөр, хувиар	61
Зураг 32.	Сүүлийн 3 жилийн хугацаанд гэмт хэргийн талаар эрх бүхий байгууллагад мэдэгдээгүй шалтгаан, сонгосон гэмт хэргийн төрлөөр, хувиар	62
Зураг 33.	Сүүлийн 3 жилийн хугацаанд цагдаагийн байгууллага мэдээллийн дагуу арга хэмжээ авсан байдал, хувиар	62
Зураг 34.	Сүүлийн 3 жилийн хугацаанд иргэдийн эрх бүхий байгууллагуудын гэмт хэргийн мэдээлэлд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны сэтгэл ханамж, эрх бүхий байгууллагаар, дүнд эзлэх хувиар	63
Зураг 35.	Хохирогч болон гэмт этгээдийн хамаарал, гэмт хэргийн төрлөөр, хувиар	65
Зураг 36.	Хамгийн их хулгайлагдсан эд зүйлс, сүүлийн 12 сарын байдлаар, хувиар	70
Зураг 37.	Хулгайлах гэмт хэрэг үйлдэгдсэн газар, сүүлийн 12 сарын байдлаар, байршлаар, дүнд эзлэх хувиар	70
Зураг 38.	Хулгайлах гэмт хэрэг болсон байршил, сүүлийн 12 сарын байдлаар, дүнд эзлэх хувиар	70
Зураг 39.	Хулгайлах гэмт хэргийн талаар эрх бүхий байгууллагад мэдэгдсэн байдал, сүүлийн 12 сарын байдлаар, хувиар	71
Зураг 40.	Хулгайлах гэмт хэргийн талаар эрх бүхий байгууллагад мэдэгдээгүй шалтгаан, сүүлийн 12 сарын байдлаар, хувиар	72
Зураг 41.	Сүүлийн 12 сарын хугацаанд малаа хулгайд алдсан өрх, малын төрөл, хувиар	73
Зураг 42.	Сүүлийн 12 сарын хугацаанд малаа хулгайд алдсан өрх, бүс, байршлаар, хувиар	74
Зураг 43.	Сүүлийн 12 сарын хугацаанд малаа хулгайд алдсан өрхийн тоо, малын тоогоор	74
Зураг 44.	Хүчирхийллийн улмаас хохирсон байдал, сүүлийн 12 сарын байдлаар, хүчирхийллийн хэлбэрээр, хувиар	77

Зураг 45.	Хүчирхийллийн улмаас хохирсон байдал, сүүлийн 12 сарын байдлаар, төрлөөр, хувиар	77
Зураг 46.	Хүчирхийллийн улмаас хохирсон байдал, сүүлийн 12 сарын байдлаар, төрлөөр, байршлаар, хувиар	78
Зураг 47.	Гэр бүлийн хүчирхийлэлд нөлөөлсөн хүчин зүйлс, сүүлийн 12 сарын байдлаар, хувиар	78
Зураг 48.	Хүчирхийллийн улмаас гэмтэл, хор уршиг учирсан байдал, сүүлийн 12 сарын байдлаар, гэмтэл, хор уршгийн төрлөөр, хувиар	79
Зураг 49.	Хүчирхийлэл үйлдсэн хүн, сүүлийн 12 сарын байдлаар, хүйсээр	79
Зураг 50.	Хүчирхийллийн талаар эрх бүхий байгууллагад мэдэгдсэн эсэх, сүүлийн 12 сарын байдлаар, дүнд эзлэх хувиар	79
Зураг 51.	Хүчирхийллийн талаар эрх бүхий байгууллагад мэдэгдээгүй шалтгаан, сүүлийн 12 сарын байдлаар, хувиар	80
Зураг 52.	Ялгаварлан гадуурхсан хүнийг таньдаг эсэх, дүнд эзлэх хувиар	81
Зураг 53.	Ялгаварлан гадуурхах гэмт хэрэг болсон газрын байршил, сүүлийн 12 сарын байдлаар, дүнд эзлэх хувиар	82
Зураг 54.	Ялгаварлан гадуурхах гэмт хэрэг болсон газрын байршил, үйлдлийн чадварын хүндрэлтэй эсэх, сүүлийн 12 сарын байдлаар, хувиар	83
Зураг 55.	Ялгаварлан гадуурхах гэмт хэргийн хохирогч болсон иргэд, ялгаварлан гадуурхалтын төрөл, сүүлийн 12 сарын байдлаар, хувиар	83
Зураг 56.	Ялгаварлан гадуурхах гэмт хэргийн хохирогч болсон иргэд, ялгаварлан гадуурхалтын зарим төрөл, бүс, сүүлийн 12 сарын байдлаар, дүнд эзлэх хувиар	84
Зураг 57.	Ялгаварлан гадуурхах гэмт хэргийн талаар эрх бүхий байгууллагад мэдэгдсэн эсэх, сүүлийн 12 сарын байдлаар, хувиар	84
Зураг 58.	Ялгаварлан гадуурхах гэмт хэргийн талаар эрх бүхий байгууллагад мэдэгдээгүй шалтгаан, сүүлийн 12 сарын байдлаар, хувиар	84
Зураг 59.	Сүүлийн 12 сард бие махбодын хохирол амссан, бэлгийн дарамтад орсон хүн амын эзлэх хувь, хүйсээр	85
Зураг 60.	Сүүлийн 12 сарын хугацаанд бие бялдар, сэтгэл санааны, бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүн амын эзлэх хувь, хүйсээр	86
Зураг 61.	Амьдардаг орчиндоо ганцаараа алхахад аюулгүй байдлыг мэдэрдэг хүн амын эзлэх хувь, хүйсээр, 2016-2023 оноор	87
Зураг 62.	18 хүртэлх насандаа бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан 18-29 насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь, улсуудаар, 2014-2023	88

СУДАЛГААНЫ ТОЙМ

Энэхүү судалгаа нь зөвхөн гэмт хэргийн хохирогч, хохирол төдийгүй иргэдийн амьдрах орчин, аюулгүй байдал, гэмт хэргээс айх айдас, гэмт хэргийн талаарх иргэдийн үзэл бодол, гэмт хэргийн нийгмийн эмзэг бүлэгт үзүүлж буй нөлөө, гэмт хэргийн бүртгэл, мэдээллийн бодит байдал, хүн амын гэмт хэргийн талаар мэдээлэх хандлага, хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагад иргэдийн итгэх итгэл, нуугдмал гэмт хэргийн шинж байдал зэрэг өргөн хүрээтэй мэдээллийг цуглуулснаараа онцлог юм. Энэхүү түүвэр судалгааны үр дүн нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого, үйл ажиллагааны үр нөлөөг дүгнэх шалгуур үзүүлэлтийн суурь болно гэдэгт итгэлтэй байна.

ГЭМТ ХЭРЭГТ ХОХИРОХ ЭРСДЭЛ

Гэмт хэрэгт хохирох эрсдэл гэдэг нь хувь хүн эсвэл бүлэг хүмүүс тодорхой төрлийн гэмт хэргийн хохирогч болох магадлалыг илэрхийлдэг ойлголт юм. Энэ эрсдэл нь тухайн хүний амьдралын хэв маяг, амьдрах орчин, эдийн засгийн нөхцөл байдал, нас, хүйс, боловсрол, ажил мэргэжил зэрэг олон хүчин зүйлсээс хамаардаг. Улс орны нийгмийн хөгжлийн шалгуур үзүүлэлтүүдийн нэг нь тухайн нийгмийн гишүүд аливаа хууль бус үйл ажиллагаанаас хохирох эрсдэлээс баттай хамгаалагдсан байх явдал бөгөөд иргэдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээг тасралтгүй үр ашигтай явуулах, хохирсон тохиолдолд хөндөгдсөн эрхийг нөхөн сэргээх эрх зүйн тогтолцоо, үйл ажиллагааны зохистой нөхцөлийг цогцоор нь бүрдүүлэх явдал нь аль ч улсын хувьд чухал байдаг.

АМЬДРАХ ОРЧНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ

Хүн амьдарч буй орчиндоо гэмт хэрэг, байгалийн гамшиг, осол, эрүүл мэндийн эрсдэл зэрэг аюулаас хамгаалагдсан, тав тухтай байх нөхцөл нь амьдрах орчны аюулгүй байдал юм. Энэ нь хувь хүний амьдралын чанарт шууд нөлөөлдөг гол хүчин зүйл мөн.

Хотжилт нь аливаа улс оронд, ялангуяа хөгжиж буй орнуудад гэмт хэрэг, хүчирхийлэл, хууль бус байдлын түвшинг нэмэгдүүлсээр байх бөгөөд хотын оршин суугчдын аюулгүй байдлын асуудал нь дэлхий даяар тулгарч буй томоохон сорилтуудын нэг хэвээр байна. Манай улсын хувьд хотжилт, хэт төвлөрлөөс хамааран иргэдийн амьдрах орчны таатай нөхцөлийг хангахад бэрхшээл тулгарсаар байна. Тухайлбал, судалгаанд хамрагдсан нийслэлийн арван иргэн тутмын 5 нь авто машины зогсоол, хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламж, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан

орц, гарц байхгүй гэх мэтээр амьдрах орчны таатай нөхцөл хангагдаагүй гэж үзсэн байна. Дэд бүтцийг сайжруулах замаар хот, суурин газрын хэт төвлөрлийг бууруулан хүн амын амьдрах орчныг сайжруулах шаардлагатай байгааг судалгааны үр дүн мөн харууллаа.

Сууцны нөхцөл нь амьдрах орчны аюулгүй байдлыг тодорхойлох чухал хүчин зүйл бөгөөд стандартын шаардлага хангаагүй эрсдэлтэй сууцанд амьдрах нь гэмт хэрэг, осол, эрүүл мэндийн эрсдэлд өртөх магадлалыг нэмэгдүүлдэг бол сайн нөхцөлтэй сууц нь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх болон амьдрах орчны тайван байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэх нь дамжиггүй. Судалгаанаас харахад амьдрах орчны таатай нөхцөл хангагдсан гэж үздэг эсэх нь өрхийн сууцны төрлөөс хамааран ялгаатай байна. Тухайлбал, бие даасан тохилог сууцанд амьдардаг иргэдийн 83.3 хувь амьдрах орчны таатай нөхцөл нь хангагдсан гэж үзсэн бол орон сууцны байшин, гэр, сууцны тусдаа байшинд амьдардаг иргэдийн арван хүн тутмын 5 нь л амьдрах орчны таатай нөхцөл хангагдсан гэж хариулсан. Харин зориулалтын бус сууцанд амьдардаг иргэдийн 77.4 хувь нь амьдрах орчны таатай нөхцөл хангагдаагүй гэжээ.

Нийслэлд амьдардаг иргэдийн 50.6 хувь нь тогтоосон эрх зүйн хэм хэмжээ, хууль, дүрэм, журам зөрчдөг олонхүн байдаг гэж хариулсан. Харин аймгийн төв (63.9 хувь), сумын төв (66.2 хувь), хөдөөгийн иргэдийн (75.5 хувь) дийлэнх нь тогтоосон эрх зүйн хэм хэмжээ, хууль, дүрэм, журам зөрчдөг хүн олон байдаггүй гэж хариулжээ. Өрхийн амьдарч буй сууцны төрлөөр авч үзвэл орон сууцанд амьдардаг иргэд бусад төрлийн сууцанд амьдардаг иргэдтэй харьцуулахад өндөр буюу арван иргэн тутмын 5 нь тогтоосон эрх зүйн хэм хэмжээ, хууль, дүрэм, журам зөрчдөг олон хүн байдаг гэдгийг илэрхийлсэн байна. Энэ нь орон сууцны байшинд амьдрах нэг сул талыг илэрхийлж байж магадгүй үзүүлэлт бөгөөд хөршүүд ойрхон амьдрах нь дуу чимээ, хөл хөдөлгөөн их байх, эрүүл ахуйн дэглэм сахихгүй байх, нийтийн өмч болох орц, цахилгаан шат зэрэг орон зайн ашиглалт муу байх зэрэг олон асуудлыг дагуулдаг болохыг харуулж байх талтай.

Нийслэлийн арван иргэн тутмын 7, үүнээс ажил эрхэлдэг арван иргэн тутмын 6 нь замын түгжрэл ихтэй газар амьдарч байна. Замын түгжрэл нь хүний өдөр тутмын амьдралын чанар, цаг ашиглалт, эрүүл мэндэд шууд байдлаар нөлөөлж байна. Тухайлбал, хүний чөлөөт цаг багасан нийгмийн харилцааны чанарт муугаар нөлөөлөх, стрессийг нэмэгдүүлэн амьдралын сэтгэл ханамжийг бууруулах, агаарын бохирдол үүсгэн эрүүл мэндэд муугаар нөлөөлөх зэрэг сөрөг үр дагавар ихтэй учраас замын түгжрэл нь зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай асуудлын нэг гэдэг нь

тодорхой юм. Нийслэл хотын замын түгжрэлийн асуудал иргэдийн амьдрах орчны аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлдэг хамгийн том хүчин зүйлийн нэг байсаар байна.

Уул уурхайн олборлолт, эрдэс бодисын үйлдвэр болон хүнд үйлдвэрлэл нь иргэдийн амьдрах орчны аюулгүй байдалд, тухайлбал орон нутгийн иргэдийн амьдралд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл ихтэй учраас энэ чиглэлийн тодруулах асуултыг асуулгад оруулсан. Сумын төвийн иргэдийн 68.4 хувь, хөдөөгийн иргэдийн 81.6 хувь амьдарч байгаа газарт нь хүнд үйлдвэрлэл, уул уурхай ашигт малтмал олборлолтын улмаас байгаль, экологийн тэнцвэрт байдал алдагдсан гэж хариулсан. Энэ дундаа баруун бүсийн иргэдийн 84.6 хувь уул уурхай ашигт малтмал олборлолтын улмаас байгаль, экологийн тэнцвэрт байдал алдагдсан гэж хариулсан нь бусад бүстэй харьцуулахад өндөр үзүүлэлт байв.

Мөн бид бэлчээрийн даацтай холбоотойгоор судалгаанд хамрагдсан сумын төвийн болон хөдөөгийн иргэдээс бэлчээрийн даац хэтэрсэн эсэх, түүний үзүүлсэн нөлөөний талаар асууж судалсан болно. Судалгаагаар сумын төвийн иргэдийн 58.7 хувь, хөдөөгийн иргэдийн 70.5 хувь нь бэлчээрийн даац хэтэрсэн гэж хариулсан байна. Түүнчлэн бүсээр авч үзвэл, Баруун бүсийн хувьд хамгийн өндөр буюу арван иргэн тутмын 7 нь бэлчээрийн даац хэтэрсэн гэв. Иргэдийн хариултаас харахад бэлчээрийн даац хөдөө орон нутгийн хувьд хамгийн тулгамдсан асуудал болсон байна.

ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд иргэд хоорондын харилцаа чухал үүрэгтэй бөгөөд нийтийн аюулгүй байдлыг хангахад иргэн бүрийн идэвхтэй оролцоо шаардлагатай байдаг. Түүнчлэн иргэд хоорондын эерэг харилцаа нь итгэлцэл, хариуцлага, хамтын ажиллагааг бий болгож, гэмт хэргийн эрсдэлийг бууруулахад томоохон хувь нэмэр оруулах боломжтой юм.

Сайн хөршийн харилцаа нь гэмт хэргийн сэжигтэй үйлдлийг мэдээлэх, таслан зогсоох, шуурхай илрүүлэх боломжийг нэмэгдүүлдэг төдийгүй дахин гэмт хэрэг үйлдэх эрсдэлийг бууруулдаг. Судалгаагаар иргэдээс хөрш болон саахалт айлын хүмүүсээ таньдаг эсэх талаар асуухад арван хүн тутмын 6 нь хөрш болон саахалт айлын хүмүүсээ сайн мэддэг гэсэн хариулт өгсөн нь эерэг үзүүлэлт юм. Гэхдээ энэ үзүүлэлт байршлаар нэлээд ялгаатай байна. Тухайлбал, нийслэлийн иргэдийн 40.6 хувь нь хөршөө сайн мэддэггүй гэсэн бол сумын төвийн иргэдийн 89.2 хувь, хөдөөгийн иргэдийн 92.2 хувь нь саахалт айлын хүмүүсээ сайн мэддэг гэсэн байна.

Хөршийн сайн харилцаа гэдэг нь хөрш болон саахалт айлын хүмүүс ямарнэгэнасуудал, хүндрэлүүссэн үед нэгэндээ туслалцаа үзүүлдэг, бусдын халдлагад өртөж буй хүүхдэд туслахад бэлэн байдаг болон гэмт хэргийг харсан даруйдаа цагдаагийн байгууллагад мэдээлэл өгдөг иргэдийн хувийг харуулна. Сумын төвд амьдардаг иргэдийн 74.7 хувь хөршийн сайн харилцаатай байгаа бол нийслэлийн хувьд 43.7 хувьтай байна. Мөн уг үзүүлэлтийг сууцны төрлөөр авч үзвэл бие даасан тохилог сууц буюу хауст амьдардаг иргэд хамгийн сайн хөршийн харилцаатай байдаг бол орон сууцны байшинд амьдардаг иргэдийн хөршийн харилцаа муу байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэдийн гэмт хэргийн талаарх үзэл бодол чухал нөлөө үзүүлдэг гэж үздэг.. Гэмт хэргийн гаралт өсөх, буурах талаарх иргэдийн төсөөлөл нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгт хохирох эрсдэлээс сэрэмжлэхэд эерэг нөлөөтэй ч нөгөө талаас иргэдийн гэмт хэргээс айх айдсыг нэмэгдүүлэх сөрөг талтай байж болно. Нийт иргэдийн 33.9 хувь нь улсын хэмжээнд гэмт хэрэг өснө гэсэн төсөөлөлтэй байгаа бөгөөд нийслэлийн иргэд гэмт хэргийн гаралт хамгийн ихээр өснө гэж хариулжээ. Тэд гэмт хэргийн гаралт өсөх гол шалтгаан нь архидалт, ажилгүйдэл, ядуурал гэж үзсэн байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ерөнхий хандлага нь иргэд өөрсдийгөө гэмт хэргийн хохирогч болж болзошгүй гэсэн хариу үйлдэл боловч ийм мэдрэмж төрж байгаа нь амьдарч буй орчны нөхцөл байдалтай шууд холбоотой байдаг. Тиймээс амьдралын ямар хэв маягтай байх нь хохирогч болох магадлалыг нэмэгдүүлэх вэ гэдгийг ойлгох нь тун чухал юм. Судалгаагаар бид иргэдийн гэмт хэргийн талаарх үзэл бодлоос гадна тэдний айдсын мэдрэмжийг тоон дүнгээр харуулахыг зорьсон болно.

Иргэдийн дийлэнх хувь нь үдэш, шөнө гэртээ ганцаараа байхад аюулгүй санагддаг гэдгээ илэрхийлсэн ч хүйс, байршил, сууцны төрлөөс хамааран бага зэрэг ялгаатай байна. Тодруулбал, эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 2.5 дахин илүү аюул, айдсын мэдрэмж авдаг. Мөн нийслэлд амьдардаг иргэд болон зориулалтын бус сууц, гэрт, сууцны тусдаа байшинд амьдардаг иргэдэд аюул, айдсын мэдрэмж илүү төрдөг байна.

Иргэдийн олонх нь олон нийтийн газарт аюулгүй гэсэн хариулт өгсөн хэдий ч эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү аюул, айдсын мэдрэмж төрдөг байна. Энэ тоо баримт нь эмэгтэйчүүд нийгмийн амьдралд оролцохдоо илүү айдастай байдгийг илэрхийлэх бөгөөд эмэгтэйчүүд, хүүхдүүдэд ээлтэй айдасгүй, аюулгүй орчинг бий болгох нийгмийн шаардлага байгааг илтгэж байна.

Сургуулийн орчинд аюулгүй санагддаг эсэхийг байршлаар харахад төвлөрсөн хот суурин газраас алслагдах тусам буюу төвлөрөл багасахад аюулгүй гэж хариулсан хариулт нэмэгдэж байна. Нийслэлийн иргэдийн 41.4 хувь нь сургуулийн орчинг аюултай гэж дүгнэсэн бол аймгийн төвд 24.2 хувь, сумын төвийн иргэдийн 17.1 хувь, хөдөө амьдардаг иргэдийн 15.5 хувь нь тус тус сургуулийн орчинг аюултай гэж хариулжээ.

Сургуулийн орчин аюулгүй санагддаг эсэхийг насны бүлгээр харахад 30-34 настай иргэд илүүтэйгээр сургуулийн орчинг аюултай орчин гэж хариулсан бол 14-17 насныхны 78.5 хувь сургуулийнхаа орчинг аюулгүй гэж үзсэн нь хамгийн өндөр хувьтай байна. Сургуулийн орчин аюулгүй гэж арван хүүхэд тутмын 8 нь үзэж байгаа нь эерэг үзүүлэлт хэдий ч арван хүүхэд тутмын 2 нь сургуулийн орчин аюултай гэж үзсэн нь мөн анхаарахгүй өнгөрч болохгүй тоон үзүүлэлт юм. Сургуулийн орчинг аюулгүй, айдасгүй болгосноор хүүхдүүд сэтгэл санааны хувьд илүү тайван байх, амжилттай суралцах, сэтгэц болон биеийн эрүүл мэндийн хувьд ч дэмжигдсэн байдалтай өсч хөгжих боломжтой юм. Мөн аюулгүй орчин нь хүүхэд, залуусын хоорондын харилцааг сайжруулж, хүчирхийлэл болон бусад сөрөг үйлдэл гарах нөхцөлийг бууруулна.

Гэмт хэргийн хохирогч болох айдас нь олон хүний амьдралд тодорхой хэмжээний сэтгэл зүйн дарамт учруулдаг, нийгмийн аюулгүй байдалтай холбоотой хамгийн түгээмэл айдас юм. Өөрөөр хэлбэл гэмт хэргээс айх айдсыг бие махбодод гэмтэл учруулах аюулаас үүдэлтэй айдас, түгшүүрийн мэдрэмж гэж тодорхойлж болно. Иргэдийн гэмт хэргийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэхийн тулд зөв мэдээлэл өгөх, өөрийгөө хамгаалах ур чадварыг эзэмшүүлэх, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх зэргээр гэмт хэргийн хохирогч болох айдсыг бууруулах боломжтой байдаг. Энэхүү судалгаагаар бид тодорхой төрлийн гэмт хэргээс айх айдсын талаарх мэдээллийг нэгтгэж харуулахыг зорилоо.

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч болохоос айдаг иргэд нийслэлд хамгийн өндөр буюу 61.9 хувийг эзэлж байна. Харин сумын төвийн иргэд харьцангуй айдас багатай байна. Хэн нэгэн хүчирхийлэгч оронд байранд нь хууль бусаар нэвтрэх, амь нас, эрүүл мэндэд нь халдах гэсэн айдас хүн амын дунд илүү давамгайлах шинжтэй байна. Мөн 14 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн 35.2 хувь нь хэн нэгний бэлгийн хүчирхийлэлд өртөхөөс айдаг гэж хариулжээ.

Иргэд гэмт хэрэгт хохирохоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор өөрийгөө болон гэр бүлийн гишүүдээ мөн эд хөрөнгөө хамгаалах үйлдлийг хийдэг. Энэ үйлдлийг идэвхтэй болон идэвхгүй гэж ангилж үзнэ. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх идэвхтэй үйлдлийн нэг болох өөрийгөө хамгаалах

зорилгоор бие хамгаалах болон дохио өгөх ямар нэгэн хэрэгсэл авч явдаг иргэд улсын дунджаар 8.3 хувь буюу бага үзүүлэлттэй байна. Нийслэлийн иргэдийн арван хүн тутмын 1 нь өөрийгөө хамгаалах ямар нэгэн хэрэгсэл авч явдаг гэж хариулсан нь бусад байршилтай харьцуулахад өндөр байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, төрөлжүүлэх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь гэмт хэрэгт хохирогч болох эрсдэлийг бууруулахад зайлшгүй чухал болж байна.

ГЭМТ ХЭРЭГТ ХОХИРСОН БАЙДАЛ

НҮБ-ын “Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирогчдын талаарх хууль цаазын үндсэн зарчмын тухай тунхаглал”-д гэмт хэргийн хохирогч гэж гэмт хэрэг, эрх мэдлээ хортойгоор ашигласан болон хүний эрх, хүмүүнлэгийн эрх зүйг зөрчсөн үйлдэл, эс үйлдлийн улмаас бие эрхтэн, оюун сэтгэхүйн хэвийн үйл ажиллагаа алдагдсан, сэтгэл санааны зовлон шаналалд автсан, эд материалын хохирол хүлээсэн, үндсэн эрх, эрх чөлөө нь ноцтой зөрчигдсөн хувь хүн болон хэсэг бүлэг хүмүүсийг хэлнэ гэж тодорхойлсон байна.

Энэ хэсэгт сүүлийн гурван жил болон сүүлийн 12 сарын хугацаанд иргэдийн гэмт хэргийн улмаас хохирсон байдлын талаарх мэдээллийг гаргахыг зорилоо. Ингэхдээ 6 гэмт хэргийн төрлийг өрхөд чиглэсэн (тээврийн хэрэгсэл хулгайлах, тээврийн хэрэгслийн эд анги хулгайлах, унадаг дугуй хөдөлгөөнт хэрэгсэл хулгайлах, орон байрны хулгай, мал хулгайлах, зам тээврийн осол) гэмт хэрэг, 10 гэмт хэргийн төрлийг хувь хүнд чиглэсэн (дээрэмдэх, хулгайлах, залилах, хахууль, хүчирхийлэл, заналхийлэх, цахим гэмт хэрэг, ялгаварлан гадуурхалт, бэлгийн хүчирхийлэл, бэлгийн дарамт учруулах) гэмт хэрэг гэж ангилан авч үзсэн.

Нийт өрхийн 31.2 хувь сүүлийн 3 жилийн хугацаанд өрхөд чиглэсэн гэмт хэргийн хохирогч болж, үүнээс 14 ба түүнээс дээш насны хүн амын 24.6 хувь нь хувь хүнд чиглэсэн гэмт хэргийн хохирогч болсон байна.

Судалгааны үр дүнгээс Монгол Улсад үйлдэгддэг хамгийн түгээмэл гэмт хэргийг ялгаж харах боломжтой. Тодруулбал, судалгаанд хамрагдахаас өмнөх сүүлийн 3 жил болон сүүлийн 1 жилийн хугацаанд хамгийн олон хүн хохирогч болсон хэргүүд хулгайлах, залилах, мал хулгайлах хэргүүд байна. Сүүлийн 3 жилийн байдлаар 14 ба түүнээс дээш насны арван хүн тутмын 1 нь хулгайлах (12.4 хувь), залилах (10.6 хувь) болон мал хулгайлах (8.0 хувь) гэмт хэргийн хохирогч болжээ.

Үйлдэгдсэн гэмт хэргийн тоо, хохирсон хүний тооны мэдээлэл шууд уялдаатай бөгөөд хохирсон гэмт хэргийн төрөл болон үйлдэгдсэн гэмт хэргийн төрлийн ерөнхий хандлага ижил байгаа хэдий ч нэг гэмт хэргийн хувьд нэлээн ялгаа харагдана. Тодруулбал, сүүлийн 3 жил болон сүүлийн 12 сарын хугацаанд үйлдэгдсэн гэмт хэргийн тоонд хүчирхийлэл үйлдсэн тохиолдлын тоо их байна. Сүүлийн 3 жилд хүчирхийллийн гэмт хэрэгт 968 иргэн хохирсон байхад хүчирхийллийн гэмт хэргийн тохиолдлын тоо 2260 буюу хохирогчийн тооноос 2.3 дахин их харин сүүлийн 12 сарын хугацаанд хүчирхийллийн гэмт хэрэгт 526 иргэн хохирсон байхад хүчирхийллийн гэмт хэргийн тохиолдлын тоо 1246 буюу 2.4 дахин их байгаа нь энэ төрлийн гэмт хэрэгт нэг хохирогч олон удаагийн давтамжтай өртөж байгааг илэрхийлэх үзүүлэлт байна.

Гэмт хэргийн хохирогч болох нь эмэгтэйчүүдэд илүү тохиолдож байна. Тодруулбал, сүүлийн 3 жилийн хугацаанд хамгийн багадаа нэг гэмт хэргийн хохирогч болсон 14 ба түүнээс дээш насны нийт хүн амын 55.1 хувь нь эмэгтэй байгаа бол сүүлийн 12 сарын хугацаанд энэ хувь 55.8 байна.

Нийслэлд хулгайлах, залилах, ялгаварлан гадуурхах, зам тээврийн ослын, аймгийн төвд залилах, хүчирхийлэх, ялгаварлан гадуурхах, хулгайлах, сумын төвд мал хулгайлах, хүчирхийлэх, залилах, хөдөөд мал хулгайлах, ялгаварлан гадуурхах гэмт хэрэгт хохирогч илүү давамгайлж байна. Гэмт хэрэгт хохирсон байдал бүсийн хувьд ямар ялгаатай байгаа нь бас сонирхолтой бөгөөд Зүүн (12.4 хувь), Баруун (8.4 хувь), Хангайн (6.7 хувь) бүсийн хувьд мал хулгайлах гэмт хэрэгт хохирогч хамгийн их байна.

Бодит амьдрал дээр хүмүүс ямар нэг гэмт хэргийн хохирогч болсноо эрх бүхий байгууллагад мэдэгдээгүй өнгөрөх тохиолдол байдаг. Энэхүү судалгааны нэг гол зорилго нь нуугдмал гэмт хэргийн мэдээллийг илрүүлэх бөгөөд судалгааны асуулгад хохирогч болсон иргэдээс эрх бүхий байгууллагад мэдэгдсэн эсэх, мэдэгдээгүй бол яагаад мэдэгдээгүй шалтгааныг лавлан асуусан. Үр дүн бидэнд нуугдмал гэмт хэрэг буюу цагдаагийн байгууллагад мэдэгдээгүй, бүртгэгдээгүй гэмт хэрэг харьцангуй их байх магадлалтайг харуулж байна. Бүс, суурьшлаар харвал хоорондын ялгаа бараг байхгүй бөгөөд сүүлийн 3 жилд гэмт хэргийн хохирогч болсон арван хүн тутмын 2-3 нь эрх бүхий байгууллагад хандаж, 7-8 нь хандаагүй байна. Гэмт хэргийг мэдээлэхгүй орхих шалтгааныг судлах нь магадгүй хууль хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын үйл ажиллагаанд чухал байж болох юм.

Иргэд аль төрлийн гэмт хэргийг эрх бүхий байгууллагад мэдэгддэг, алийг нь мэдээлдэггүй талаар үзэхэд дараах байдалтай байна. Тухайлбал, сүүлийн 3 жилийн хугацаанд гэмт хэргийн хохирогч болсон 14 ба түүнээс дээш насны хүн амын 72.3 хувь нь тээврийн

хэрэгслийн хулгайг, 66.7 хувь нь зам тээврийн ослыг, 48.7 болон 47.0 хувь нь орон байрны хулгай, малын хулгайг эрх бүхий байгууллагад мэдээлсэн нь хамгийн өндөр байна. Харин хахуулийн гэмт хэргийн талаар 2.4 хувь, ялгаварлан гадуурхалтын гэмт хэргийн талаар 5.7 хувь, бэлгийн хүчирхийллийн талаар 8.8 хувь, бэлгийн дарамт учруулсан гэмт хэргийн талаар 10.4 хувь нь эрх бүхий байгууллагад мэдээлсэн байв.

Гэмт хэргийн талаар цагдаагийн байгууллагад мэдэгдсэн гэж хариулсан иргэдийн 52.3 хувь нь цагдаагийн байгууллага мэдээллийн дагуу тодорхой арга хэмжээ авсан гэж хариулсан байна. Эсрэгээрээ иргэдийн цагдаад мэдэгдсэн гэмт хэргийн 44.3 хувьд нь ямар нэгэн арга хэмжээ аваагүй эсвэл авсан ч иргэдэд эргэж мэдэгдээгүй байна. Энэ нь цагдаад мэдэгдсэн гэмт хэргийг хэрхэн шийдвэрлэсэн талаар тухайн иргэнд мэдээлэл өгөх шаардлагатайг харуулж байна.

Гэмт хэргийн зарим төрлүүдэд гэмт хэрэг гарсан хугацааг улирлаар харахад унадаг дугуй, хөдөлгөөнт хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, түүний эд ангитай холбоотой хулгай, бэлгийн хүчирхийлэл, орон байрны хулгайн гэмт хэрэг зуны улиралд илүү үйлдэгдсэн байгаа ба хахууль, ялгаварлан гадуурхалт, зам тээврийн осол, цахим халдлага, малын хулгайн хэрэг намрын улиралд илүү үйлдэгдсэн байв.

Дээр дурдсанчлан хүчирхийлэл Монгол Улсад түгээмэл, ялангуяа давтамж өндөртэй гардаг гэмт хэргийн нэг гэдгийг тоо баримт харуулсан. Хүчирхийлэл, тэр дундаа гэр бүлийн хүчирхийлэл нуугдмал явагддаг гэмт хэргийн тоонд ордог.

Судалгааны үр дүнгээр хүчирхийлэл болон заналхийллийг хохирогчийн эхнэр/нөхөр, хамтран амьдрагч нь хамгийн ихээр үйлддэг гэжээ. Эхнэр/нөхөр, хамтран амьдрагч үйлдэж буй энэ гэмт хэрэг нь гэр бүлийн хүчирхийллийн хамгийн тод илрэл бөгөөд энэ гэмт хэргийн хохирогч нь ихэвчлэн эмэгтэйчүүд, хүүхдүүд, өндөр настангууд байдаг. Энэ гэмт хэргийн нэг аюул нь ихэнхдээ гэр бүлийн хүрээнд нууцлагддаг тул хуулийн байгууллагад мэдэгдэхгүй, илрэхгүй өнгөрөх нь элбэг. Энэ нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт бодит байдалд ямар байгааг анхаарч, тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатайг илтгэж байна.

Харин ялгаварлан гадуурхалтыг найз нөхөд болон хамтран ажиллагч илүү гаргаж байгаа нь анхаарахгүй өнгөрч болохгүй гэмт хэргийн нэг төрөл юм. Энэ төрлийн гэмт хэргийг бууруулах нэг оновчтой арга нь хүний эрх, тэгш эрхийн талаар нийгмийн боловсролыг дээшлүүлэх, ялгаварлан гадуурхалтын хор уршгийн талаар мэдлэг мэдээлэл олгох юм.

Судалгаагаар бид тухайн гэмт хэрэг үйлдэгдэх үед гэмт хэрэгтэн болон хохирогчийг согтуу эсвэл мансуурсан байсан эсэхийг асууж тодруулсан. Хүчирхийлэх (31.7 хувь) болон заналхийлэх (36.8 хувь) гэмт хэргийг арван гэмт хэрэгтэн тутмын 3 нь согтуу болон мансуурсан байхдаа үйлддэг байна.

Судалгаагаар зарим гэмт хэргийн төрлүүдийн хувьд гэмт хэрэг болсон байршилд хяналтын камертай байсан эсэхийг асуусан ба дийлэнх хувь нь хяналтын камер байгаагүй гэж хариулжээ. Тухайлбал, хулгайн гэмт хэрэгт хохирсон нийслэлийн иргэдийн 14.8 хувь нь хулгай болсон байршилд хяналтын камер байсан, 73.3 хувь нь камер байгаагүй гэж хариулжээ.



ТАНИЛЦУУЛГА

Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгаа нь гэмт хэргийн хохирогч, түүний шинж байдал, гэмт хэргийн хохирол, түүнийг барагдуулахад хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, иргэдийн итгэх итгэл, гэмт хэрэгт хохирох байдалд нөлөөлж буй хүчин зүйлс, иргэдийн гэмт хэргээс айх айдас, гэмт хэргийн талаарх ойлголт, хэрэг бүртгэх байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн мөрөөр явуулж буй урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар болон ТХЗ-ын холбогдох үзүүлэлтүүд тооцоход шаардлагатай суурь мэдээллийг бий болгох зорилготой юм. Энэхүү судалгааг 1990-ээд оноос эхлэн дэлхийн 80 гаруй улс орон зохион байгуулж ирсэн байна.

Монгол Улсын Статистикийн тухай хуулийн 7-р зүйлийн 1 дэх хэсгийн “м”-д “Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгааг гурван жил тутам” зохион байгуулан явуулна гэж заасны дагуу гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгааг анх удаа НҮБ-ын Мансууруулах Бодис, Гэмт Хэрэгтэй Тэмцэх Газрын техникийн дэмжлэгтэйгээр, НҮБ-ын Гэмт Хэрэг, Мансууруулах Бодистой Тэмцэх Газар болон Европын Эдийн засгийн комиссоос хамтран гаргасан Хохирогчийн судалгааны гарын авлагын дагуу зохион байгуулсан.

Уг судалгаагаар хохирогчийн эмзэг асуудлыг сануулах байдлаар асуух учраас иргэд судалгаанд оролцож, хариулт өгөхөөс татгалзах магадлал өндөр, мэдээлэл цуглуулалт, өгөгдлийн чанарт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй гэж үзсэн учраас “Амьдрах орчны аюулгүй байдлын судалгаа” гэсэн нэрээр судалгааг зохион байгуулсан. Үүнтэй ижил судалгааг БНСУ-д “Олон нийтийн аюулгүй байдлын судалгаа”, ХБНГУ-д “Амьдралын нөхцөл байдал, аюулгүй байдлын судалгаа” нэрээр зохион байгуулж байжээ. Энэхүү судалгаанд нийт 8000 өрхийг хамруулж, үр дүнг улс, бүс, суурьшлын түвшинд тооцон гаргалаа.



СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Энэ бүлэгт уг судалгааны түүвэр хийхэд болон мэдээлэл цуглуулалт, мэдээлэл боловсруулалтад ашигласан арга зүй, судалгааны мэдээллийн харьцуулалтын хязгаарлагдмал байдлын талаарх мэдээллийг оруулав.

2.1 Түүврийн арга зүй

Түүврийн хүрээ: Судалгааны түүврийн хүрээ нь 2022 оны жилийн эцсийн Монгол Улсын нийт өрх, 14 ба түүнээс дээш насны хүн ам бөгөөд 941.5 мянган өрх, 14 ба түүнээс дээш насны 2.3 сая хүн байв.

Түүврийн нэгж: Судалгааны мэдээлэл цуглуулалтын үндсэн нэгж нь өрх байна. Нэг орон байранд хамт амьдардаг нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын хэрэгцээгээ хамтран хангадаг, хэсэг бүлэг хүмүүсийг өрх гэх бөгөөд өрхийн гишүүд нь хоорондоо гэр бүл, ураг төрөл болон хамаатан садны холбоотой хүмүүс, зарим гишүүд нь огт хамааралгүй байж болно. Судалгаанд цэргийн хуаран, дотуур байр, засан хүмүүжүүлэх газар, сүм хийд болон нийтийн байранд түр амьдрагчид, байнгын орон гэргүй хүн амыг хамруулаагүй. Тухайн өрхийн ам бүлээс 6 сараас дээш хугацаагаар эзгүй байгаа (хугацаат цэргийн албан хаагч, оюутан сурагчид, гадаадад ажиллаж амьдарч байгаа болон цагдан хоригдож байгаа) хүмүүсийг өрхийн гишүүнд тооцохгүй.

Судалгааны үр дүнг тархаах түвшин: Судалгааны үр дүнг улсын болон бүсийн, байршлын түвшинд төлөөлөхүйц байхаар түүврийн дизайныг боловсруулсан.

Түүврийн хэмжээг тодорхойлох: Тодорхой нэг нутаг дэвсгэр эсвэл хүн амын бүлгийн хувьд 2 үе шаттай түүвэр судалгааны түүврийн хэмжээг дараах томъёоллын дагуу тооцсон. Үүнд:

$$n = \frac{Z^2 \times P_0 \times (1 - P_0)}{e^2} * deff * rr$$

- z = хүсч буй ач холбогдлын түвшинг тодорхойлсон статистик утга
- P_0 = түлхүүр үзүүлэлтийн тооцоо (хувийн жин)
- e = алдааны хязгаар
- $deff$ = тухайн дизайны үр ашигтай байдал /design effect/
- rr = асуулгад хариулахгүй байх байдлаар засварлагч

Дээрх томьёоллын дагуу түүврийн хэмжээг тодорхойлохын тулд эхлээд өгөгдсөн хувьсагчдын утгыг тодорхойлно. Үүнд:

- z – 95 хувийн ач холбогдлын түвшин дэх t статистикийн тархалтын утга 1.96
- P_0 – түлхүүр үзүүлэлтийн хувийн жин. (Өмнө нь ижил төрлийн судалгаа явж байгаагүй үед болон тодорхой төсөөлөл байхгүй үед =0.50)
- e – таамаглаж байгаа алдааны хязгаарыг аль болох бага хэмжээтэйгээр авах бөгөөд практикт 5-15 хувийн харьцангуй алдаатай байхад судалгааны үр дүнг ашиглаж болдог. (Бидний тохиолдолд таамаглаж байгаа харьцангуй алдааг бүсийн түвшинд 6-8 байхаар тооцсон)
- d_{eff} – тооцох боломжгүй бөгөөд бид 2.0-той тэнцүү байна гэж таамагласан.
- rr – судалгаанд 10 хүн тутмын нэг буюу 10 хувь нь ямар нэгэн шалтгаанаар хариулахгүй байна гэж үзсэн. Тэгвэл $rr = 1.1$ болно.

Хувьсагчдын утгыг дээрх байдлаар тодорхойлж, түүврийн хэмжээг бүсийн хэмжээнд тооцож гаргасан.

Түүврийн хэмжээг тэгшитгэх, хуваарилах: Улаанбаатар хотын хувьд хороодын хэсгүүд, аймгуудын хувьд багуудыг түүврийн анхан шатны нэгж (ТАШН) гэж үзнэ. Түүврийн хамралт болон төлөөлөх чадварыг нэмэгдүүлэх, алдааны магадлалыг бууруулахын тулд сонгогдсон ТАШН бүрээс 20 өрх сонгоно гэж үзэн түүврийн хэмжээг тэгшитгэсэн.

Судалгааны үр дүнг бүсийн түвшинд тархаахын тулд түүврийн хэмжээг бүсийн түвшинд тооцож, аймаг, дүүргийн өрхийн тооноос хамааруулан бүсийн дүнгээс аймаг, дүүргийн түүврийн хэмжээг пропорционалиар тооцсон. Мөн аймгийн хувьд түүврийн хэмжээг байршлын хувьд пропорционалиар хуваарилж түүврийн хэмжээг 8000 болгон тэгшитгэсэн.

Хүснэгт 1.

Судалгаанд хамрагдах өрхийн тоо, стандарт алдаа, бүсээр

Бүс	Өрхийн тоо (Түүврийн хэмжээ)	Түлхүүр үзүүлэлт	95%-ын итгэлцлийн түвшин дэх харьцангуй алдаа	Итгэх интервал		Стандарт алдаа
				Доод	Дээд	
Улаанбаатар	2800	0.5	0.052	0.47	0.54	0.01
Баруун	1200	0.5	0.080	0.46	0.54	0.02
Хангайн	1500	0.5	0.072	0.46	0.54	0.02
Төвийн	1500	0.5	0.072	0.46	0.54	0.02
Зүүн	1000	0.5	0.088	0.46	0.54	0.02
Нийт	8000	0.5	0.052	0.47	0.54	0.01

Хүснэгт 2.

Судалгаанд хамрагдах өрхийн тоо, бүс, аймаг, дүүрэг, суурьшлаар

Аймаг, дүүрэг	Нийслэл	Аймгийн төв	Сумын төв	Хөдөө
Улаанбаатар				
Багануур				
Багахангай	140			
Налайх				
Баянгол	420			
Баянзүрх	740			
Сонгинохайрхан	600			
Сүхбаатар	260			
Хан-Уул	400			
Чингэлтэй	240			
Зүүн бүс				
Дорнод		200	40	120
Сүхбаатар		80	100	100
Хэнтий		100	100	160
Төвийн бүс				
Төв		60	120	100
Говьсүмбэр		40		20
Сэлэнгэ		60	220	20
Дорноговь		60	120	20
Дархан-Уул		220	40	20
Өмнөговь		100	20	120
Дундговь		40	20	80

Аймаг, дүүрэг	Нийслэл	Аймгийн төв	Сумын төв	Хөдөө
Хангайн бүс				
Орхон		240		
Өвөрхангай		100	60	140
Булган		40	80	40
Баянхонгор		80		140
Архангай		40	80	120
Хөвсгөл		100	40	200
Баруун бүс				
Завхан		60	40	140
Говь-Алтай		60	40	80
Баян-Өлгий		100	20	160
Ховд		100	40	120
Увс		100	40	100
Нийт	2800	1980	1220	2000

Түүврийн үе шат: Түүврийг үндсэн 2 үе шаттай хийсэн бөгөөд сонгогдсон өрхөөс судалгаанд оролцох боломжтой 14, түүнээс дээш насны бүх гишүүнийг хамрууллаа.

Эхний үе шатанд Монгол Улсын нийт баг, хэсгийн жагсаалтаас харгалзах тооны түүврийн анхан шатны нэгж буюу кластеруудыг тохирох магадлалт түүврийн аргыг ашиглан сонгосон. Судалгааны ТАШН-ээр аймаг, дүүргийн баг, хэсгийг сонгосон.

Хоёрдугаар шатанд сонгогдсон ТАШН-ийн өрхийн жагсаалтаас энгийн санамсаргүй түүврийн аргыг ашиглан кластер бүрээс 20 өрх сонгов.

Түүврийн жин: Үр дүнгийн тооцоо хийх, дүн шинжилгээ боловсруулахад түүврийн жинг тооцож ашиглана. Түүврийн жинг тооцоход дараах тоо мэдээлэл шаардлагатай. Үүнд:

- Кластерын тоо;
- Сонгогдсон кластерын өрхийн тоо;
- Сонгогдсон өрхөөс судалгаанд хамрагдах боломжтой 14 ба түүнээс дээш насны хүний тоо.

Түүврийн жин нь тухайн шатанд сонгогдсон элементүүдийн магадлалын урвуу хэмжигдэхүүн байх бөгөөд дараах байдлаар тооцно:

Нэгдүгээр шатны түүврийн жин:

$$W_{1k} = \frac{A_k}{A_{ks}}$$

A_k = k дугаар бүлгийн нийт өрхийн тоо

A_{ks} = k дугаар бүлгээс сонгогдсон s ширхэг кластерийн нийт өрхийн тоо

Хоёрдугаар шатны түүврийн жин:

$$W_{2kj} = \frac{M_{kj}}{m_{kj}}$$

M_{kj} = k бүлгийн j кластерийн нийт өрхийн тоо

m_{kj} = k бүлгийн j кластерийн судалгаанд хамрагдсан өрхийн тоо

Өрхийн түүврийн жин дээрх 2 жингийн үржвэр байна:

$$W_{kj} = \frac{A_k}{A_{ks}} \cdot \frac{M_{kj}}{m_{kj}}$$

Эцэст нь 14 ба түүнээс дээш насны хүн амын түүврийн жин нь дээрх өрхийн жинг өрхөд байгаа судалгаанд хамрагдах боломжтой 14 ба түүнээс дээш насны хүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна.

2.2

Судалгааны мэдээлэл цуглуулалтад ашигласан арга

Судалгааны асуулга: Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгааны асуулга нь Өрхийн асуулга (АОАБС-1), Өрхийн гишүүний асуулга (АОАБС-2), Хохирсон байдлын асуулга (АОАБС-3) гэсэн 3 төрлийн маягтаас бүрдэнэ. Эдгээр асуулгууд нь нийт 431 асуулттай.

Өрхийн асуулга нь хаягийн хэсэг, өрхийн ерөнхий мэдээлэл, өрхийн гишүүдийн ерөнхий мэдээлэл (боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт) гэсэн хэсгүүдтэй бол Өрхийн гишүүний асуулга нь амьдрах орчны нөхцөл байдал, иргэдийн үзэл бодол, гэмт хэрэгт хохирсон байдал гэсэн 3 бүлгээс бүрдэнэ.

Хохирсон байдлын асуулга нь тухайн хариулагчийн хохирсон байдлыг гэмт хэргийн төрлөөр нарийвчлан асуух 16 хэсгээс бүрдсэн. Үүнд:

- Хэсэг 1. Тээврийн хэрэгсэл хулгайлах
- Хэсэг 2. Тээврийн хэрэгслийн эд анги хулгайлах
- Хэсэг 3. Унадаг дугуй, хөдөлгөөнт хэрэгсэл хулгайлах
- Хэсэг 4. Орон байрны хулгай
- Хэсэг 5. Дээрэмдэх
- Хэсэг 6. Хулгайлах
- Хэсэг 7. Залилах
- Хэсэг 8. Хахууль
- Хэсэг 9. Хүчирхийлэл
- Хэсэг 10. Заналхийлэх

- Хэсэг 11. Мал хулгайлах
- Хэсэг 12. Цахим халдлага
- Хэсэг 13. Зам тээврийн осол
- Хэсэг 14. Ялгаварлан гадуурхалт
- Хэсэг 15. Бэлгийн хүчирхийлэл
- Хэсэг 16. Бэлгийн дарамт учруулах

Мэдээлэл цуглуулах арга: Судалгааны мэдээлэл цуглуулалтад нүүр тулсан ярилцлагын аргыг ашиглалаа. Сонгогдсон хариулагчтай ярилцлага хийж мэдээлэл цуглуулахдаа хөдөлгөөнт төхөөрөмж ашигласан (CAPI) бөгөөд хөдөлгөөнт төхөөрөмж гацах, царцах, хөдөлгөөнт төхөөрөмжийн цэнэг нь дуусах зэрэг тохиолдолд цаасан маягтаар мэдээлэл цуглуулах аргыг хослуулан ашигласан.

Мэдээлэл боловсруулалт: CPro программ хангамж ашиглан ГХХЭС-ны мэдээлэл оруулах программыг боловсруулав. Цуглуулсан мэдээллийг боловсруулахдаа Stata/SPSS программ хангамжийг ашиглалаа.

Мэдээллийн харьцуулагдах байдал: Судалгааны асуулгыг боловсруулахдаа Нэгдсэн Үндэстний Байгууллагын Гэмт Хэрэг, Мансууруулах Бодистой Тэмцэх Газар болон Европын Эдийн засгийн комиссоос хамтран гаргасан Хохирогчийн судалгааны гарын авлага болон олон улсын хохирогчдын судалгаанд ашигласан асуулгыг мөрдлөг болгосон учир гэмт хэрэгт хохирох эрсдэл, хохирсон байдал, урьдчилан сэргийлэх арга хэмжээ зэрэг үзүүлэлтүүдийг олон улсад харьцуулах боломжтой болсон.

3

СУДАЛГААНЫ ҮНДСЭН ҮР ДҮН

Энэхүү тайланд уг судалгаагаар цуглуулсан өгөгдөлд үндэслэн өрх, хүн амын ерөнхий шинж байдал, гэмт хэрэгт өртөж хохирч болзошгүй эрсдэл, хохирсон байдал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, нуугдмал гэмт хэрэг, иргэдийн хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагад итгэх итгэл зэрэг сонирхолтой мэдээллүүдийг орууллаа.

Гэмт хэрэгт хохирох эрсдэл, хохирлын түвшин өрхийн хүн ам зүйн шинж чанартай зайлшгүй холбоотой бөгөөд өсвөр насныхан, залуучууд, хот суурин газар амьдардаг хүмүүсийн дунд хохирох эрсдэл хамгийн өндөр байгааг түүвэр судалгааны үр дүн харуулж байна. Хүн ам зүйн мэдээлэл нь хохирогчдын амьдралын хэв маягийг ойлгоход төдийлөн тус болохгүй хэдий ч тэдний амьдралын ерөнхий дүр төрхийг харуулдаг учраас хохирогчийн талаарх судалгаанд тусгах нь зүйтэй юм¹.


3.1

Судалгаанд хамрагдсан өрх, хүн амын ерөнхий шинж байдал

Энэ хэсэгт судалгаанд хамрагдсан өрх, хүн амын шинж байдлыг хүйс болон насны бүлэг, гэрлэлтийн байдал, ам бүлийн тоо, сууцны төрлөөр товч танилцуулна. Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 34.2 хувь нь нийслэлд, 26.8 хувь нь аймгийн төвд, 39.0 хувь нь сумын төв, хөдөөд амьдарч байна. Өрхийн ам бүлийн бүтцийг харвал, нийт өрхийн 14.1 хувь нь ганц бие өрх байгаа бол 2-4 ам бүлтэй өрхүүд 58.7 хувийг, 5 болон түүнээс дээш ам бүлтэй өрх 27.2 хувийг эзэлж байна.

Зураг 1.

Ам бүлийн байдал, дүнд эзлэх хувиар



¹ <https://www.cliffsnotes.com/tutors-problems/Criminal-Justice/49510526-Who-is-at-the-most-risk-of-being-a-victim-of-a-crime-Are/#:~:text=The%20elderly%2C%20those%20who%20are,criminals%20who%20committed%20the%20crime.>

Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгааны мэдээлэл цуглуулалтад орон сууцны төрлийг уламжлалт сууц буюу гэр, орон сууцны байшин, бие даасан тохилог сууц, сууцны тусдаа байшин, оюутан, сурагчдын нийтийн байр, нийтийн зориулалтын бусад байр, зориулалтын бус сууц болон бусад сууц гэсэн төрлөөр өрхөөс асуусан болно. Хүний амьдарч байгаа гэр орон аз жаргал, итгэл найдварын эх үүсвэр болж, аюулгүй, тогтвортой орчинг бүрдүүлэн хүний хөгжилд дэмжлэг болох учиртай юм². Энэхүү тайланд сууцны төрлүүдээс хамгийн түгээмэл сууцны төрлийг³ сонгон авч, зарим бага тархалттай хариултуудыг нэгтгэх байдлаар танилцуулсан болно. Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 34.4 хувь нь гэрт, 27.8 хувь нь орон сууцны байшинд, 36.5 хувь нь сууцны тусдаа байшинд, 1.3 хувь нь бусад төрлийн сууцанд амьдарч байна.

Зураг 2.**Өрхийн сууцны төрөл, дүнд эзлэх хувиар**

Амьдралын хэв маяг, дэд бүтэц зэргээс хамаарч өрхийн амьдарч буй сууцны хэлбэр бүс, суурьшлаар харилцан адилгүй байна. Тухайлбал, судалгаанд хамрагдсан Улаанбаатар хотын өрхүүдийн 14.3 хувь нь гэрт, 50.5 хувь нь орон сууцанд амьдардаг бол Баруун бүсийн өрхүүдийн талаас илүү нь буюу 53.8 хувь нь гэрт амьдарч байна. Түүнчлэн хөдөөгийн өрхийн дийлэнх буюу 73.3 хувийг гэрт амьдардаг өрхүүд эзэлдэг бол сумын төвийн өрхийн 50.7 хувь, аймгийн төвийн өрхийн 43.7 хувь нь сууцны тусдаа байшинд амьдарч байна.

² Shaun Donovan, former U.S. Secretary of Housing and Urban Development

³ Бусад төрлийн сууцны төрөлд бие даасан тохилог сууц, зориулалтын бус сууц болон нийтийн байрыг нэгтгэж оруулсан.

Хүснэгт 3.


Өрхийн сууцны төрөл, бүс, байршлаар, дүнд эзлэх хувиар

Бүс, байршил	Өрхийн амьдарч буй сууцны төрөл			
	Гэр	Орон сууцны байшин	Сууцны тусдаа байшин	Бусад төрлийн сууц
Улсын дундаж	34.4	27.8	36.5	1.3
Бүс				
Баруун	53.8	5.9	39.6	0.7
Хангай	50.0	10.3	39.2	0.6
Төв	34.4	27.2	36.7	1.7
Зүүн	43.9	18.2	33.7	4.2
Улаанбаатар	14.3	50.5	34.5	0.7
Байршил				
Нийслэл	14.3	50.5	34.5	0.7
Аймгийн төв	24.8	30.1	43.7	1.4
Сумын төв	34.9	11.8	50.7	2.7
Хөдөө	73.3	2.1	23.3	1.3

Хүн амьдран суугаа сууцаа өөрөө эзэмших эсэх нь аюулгүй байдалд нөлөө үзүүлэх нь тодорхой бөгөөд эзэмшигч нь өөрийн орон сууцныхаа аюулгүй байдлыг хариуцах бүрэн эрхтэй байснаар орчны аюулгүй байдлыг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэх болно. Өөрөөр хэлбэл, сууцаа өөрөө эзэмшиж буй хүмүүс илүү хяналттай байж эрсдэлийг бууруулах боломжтой байдаг. Судалгааны үед нийт өрхийн 90.2 хувь нь өөрийн эзэмшлийн сууцанд, 9.8 хувь нь бусдын эзэмшлийн сууцанд амьдарч байгаа бөгөөд 3.7 хувь нь түрээс төлдөг гэж мэдээлсэн байна.

Зураг 3.

Өрхийн сууцны эзэмшлийн хэлбэр, дүнд эзлэх хувиар




Сууцны эзэмшлийн хэлбэрийн хувьд хот, хөдөө мөн ялгаатай. Тодруулбал, нийслэлд бусдын сууцанд түрээс төлж амьдардаг өрх 7.3 хувь байгаа нь хамгийн өндөр бөгөөд төвлөрсөн газраас алсрах тусам бусдын сууцанд амьдрах хувь буурч өөрийн эзэмшлийн сууцанд амьдрах нь түгээмэл дүр зурагтай байна.

Хүснэгт 4.**Өрхийн сууцны эзэмшлийн хэлбэр, байршлаар, дүнд эзлэх хувиар**

Бүс, байршил	Сууцны эзэмшлийн хэлбэр		
	Өөрийн эзэмшлийн	Бусдын сууцанд: Түрээстэй	Бусдын сууцанд: Түрээсгүй
Улсын дундаж	90.2	3.7	6.1
Байршил			
Нийслэл	83.8	7.3	8.9
Аймгийн төв	91.1	2.9	6.0
Сумын төв	93.8	1.2	5.0
Хөдөө	96.4	0.8	2.8

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэмт хэрэгт илүү өртөмтгий байдаг гэдгийг зарим судалгааны ажилд онцолсон байдаг⁴. Хөгжлийн бэрхшээлтэй байх нь гэмт хэрэгт хохирох эрсдэлийг нэмэгдүүлдэг байж болох бөгөөд энэ нь бие махбодын болон сэтгэл санааны эмзэг байдлаас, нийгмийн тусгаарлалт болон дэмжлэгийн дутагдал зэрэг олон хүчин зүйлсээс үүдэлтэй байдаг. Судалгаанд хамрагдсан 14 ба түүнээс дээш насны нийт хүн амын 8.3 хувь нь үйлдлийн чадварын хүндрэлтэй байгаа бөгөөд насны бүлгээр харвал хүн амын насжилт нэмэгдэх тусам үйлдлийн чадварын хүндрэл нэмэгдэх зүй ёсны хандлагатай. 50 болон түүнээс дээш насны хүн амын 18.7 хувь нь ямар нэг хэлбэрийн үйлдлийн чадварын хүндрэлтэй байна.


Зураг 4.**Үйлдлийн чадварын хүндрэлтэй хүн ам, насны бүлгээр, хүйсээр, хувиар**

4. https://icdd.idaho.gov/wp-content/uploads/Victimization-Among-Persons-with-Disabilities_Professional-Stakeholder-Perspectives-in-Idaho-ACCESSIBLE-ENGLISH.pdf

Судалгаанд хамрагдсан өрхийн 15 ба түүнээс дээш насны гишүүдийн гэрлэлтийн байдлын мэдээллийг цуглуулсан бөгөөд 69.2 хувь нь гэрлэсэн, 18.0 хувь нь огт гэрлээгүй байв. Хүний гэрлэлтийн байдал гэмт хэргийн хохирогч болох эрсдэлд нөлөөтэй байж болох талаар судалгааны үр дүн байдаг (АНУ-ын Хууль зүйн яам, 1989)⁵.

Зураг 5.


Гэрлэлтийн байдал, хувиар



Аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгт хохирох эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чухал хүчин зүйлүүдийн нэг нь хүн амын боловсролын түвшин юм. Хүн амын боловсролын түвшин бага байх нь гэмт хэрэгт хохирох эрсдэлийг нэмэгдүүлэх нөлөөтэй. Тухайлбал, боловсрол багатай хүмүүс өөрсдийнхөө эрх, аюулгүй байдлын талаар мэдлэг муутай байх, мөн эдийн засгийн хувьд бэрхшээлтэй байх зэрэг эрсдэлтэй байдаг. Эдгээр амьдралын эрсдэлтэй байдал нь тэднийг гэмт хэрэгт өртөх эрсдэлийг нэмэгдүүлэх нөхцөл болдог байна. Иймд судалгааны асуулгад боловсролын түвшний асуултыг тусгаж хохирох эрсдэл болон хохирсон байдалтай уялдуулж үзсэн болно. Судалгаанд хамрагдсан 14 ба түүнээс дээш насны хүн амын 97.7 хувь нь бага болон түүнээс дээш боловсролтой, үүнээс арван хүн тутмын 3 нь бүрэн дунд боловсролтой, мөн арван хүн тутмын 3 нь дээд боловсролтой байна.

Зураг 6.

Хүн амын боловсролын түвшин, хүйсээр, хувиар



5. <https://nap.nationalacademies.org/read/4421/chapter/2#9>

Өрхийн орлогын хэмжээ нь гэмт хэрэгт хохирох эрсдэлд тодорхой хэмжээгээр нөлөөлөх боломжтой бөгөөд энэ нь нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, орон нутгийн онцлог, гэмт хэргийн төрлөөс хамаарч өөр өөр байж болно. Бага орлоготой өрхүүд гэмт хэрэг илүү гардаг орчинд амьдрах, хууль бус үйл ажиллагаанд татагдах эрсдэл өндөр байдаг. Харин өндөр орлоготой өрхүүд бусдын анхаарлыг татахуйц үнэт зүйлс, эд хөрөнгөтэй байдал нь хулгай, дээрэм гэх мэт эд хөрөнгийн эсрэг гэмт хэргийн бай болох эрсдэлийг нэмэгдүүлэх магадлалтай юм. Мөн өндөр орлоготой өрхүүд цахим орчинд илүү их цаг зарцуулж, санхүүгийн үйл ажиллагаа явуулдаг тул залилан, цахим халдлагад илүү өртөх зэрэг нөхцөл бүрддэг нь өрхийн орлого болон гэмт хэрэгт хохирох эрсдэлийн хамаарал өндөр байх магадлалыг нэмэгдүүлж байна. Энэхүү судалгааны асуулгад өрхийн эдийн засгийн байдлыг тодорхойлох асуудлыг өрхийн сарын дундаж орлогоор тодорхойлсон бөгөөд үр дүнгээс харвал өрхийн сарын дундаж орлого нийслэлийн өрхийн хувьд бусад бүс, байршлаас өндөр, хөдөөгийн суурьшилд бага орлоготой өрхүүд илүү төвлөрсөн байх дүр зураг харагдаж байна.

Зураг 7.

Өрхийн сарын дундаж орлого (судалгаанд хамрагдахаас өмнөх 12 сарын дундаж), бүс, байршлаар, дүнд эзлэх хувиар



3.2

Гэмт хэрэгт хохирох эрсдэл

Гэмт хэрэгт хохирох эрсдэл гэдэг нь хувь хүн эсвэл бүлэг хүмүүс тодорхой төрлийн гэмт хэргийн хохирогч болох магадлалыг илэрхийлдэг ойлголт юм. Энэ эрсдэл нь тухайн хүний амьдралын хэв маяг, амьдрах орчин, эдийн засгийн нөхцөл байдал, нас, хүйс, боловсрол, ажил мэргэжил зэрэг олон хүчин зүйлсээс хамаардаг. Улсорны нийгмийн хөгжлийн шалгуур үзүүлэлтүүдийн нэг нь тухайн нийгмийн гишүүд аливаа хууль бус үйл ажиллагаанаас хохирох эрсдэлээс баттай хамгаалагдсан байх явдал бөгөөд иргэдийг гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээг тасралтгүй үр ашигтай явуулах, нэгэнт хохирсон тохиолдолд түүний хөндөгдсөн эрхийг нөхөн сэргээх эрх зүйн тогтолцоо, үйл ажиллагааны зохистой нөхцөлийг цогцоор нь бүрдүүлэх явдал нь аль ч улс орны хувьд нэн чухал байдаг.

Гэмт хэрэгт хохирох эрсдэлд олон хүчин зүйлс нөлөөлдөг. Тодруулбал,

1. Нийгэм, эдийн засгийн хүчин зүйлс буюу ажилгүй, бага орлоготой байх, боловсролын түвшин бага байх нь гэмт хэрэгт өртөх эрсдэлийг нэмэгдүүлдэг.
2. Газарзүйн байршил буюу тухайлбал гэмт хэрэг их үйлдэгддэг бүс нутагт амьдардаг байх, мөн хот суурин газарт амьдардаг байх нь эрсдэлийг нэмэгдүүлдэг.
3. Амьдралын хэв маяг буюу олон нийтийн газраар тогтмол зорчих болон шөнийн цагаар гадуур явах, хүн цөөн, хяналт бага газар удаан хугацаагаар байх нь эрсдэлийг нэмэгдүүлдэг.
4. Хувь хүний онцлог буюу өөрийгөө хамгаалах чадваргүй байдал, үүнд өсвөр насных байх, эмэгтэй байх нь тодорхой төрлийн гэмт хэргийн хохирогч болох эрсдэлийг нэмэгдүүлдэг.
5. Харилцаа холбоо болон амьдарч буй орчин буюу хяналт, хамгаалалт, гэрэл муутай гудамж, орчин, найз нөхдийн хүрээ, ажлын орчин хохирох эрсдэлийг нэмэгдүүлэхэд нөлөөлнө.

Түүнчлэн нийгмийн хүчин зүйл болох ядуурал, эцгийн эрхт ёсны жендэрийн хэм хэмжээ (жишээ нь, эмэгтэйчүүд гэртээ байх ёстой, ажилд орохгүй байх, хүлцэнгүй байх гэх мэт) зэрэг хүчин зүйлүүд хохирох эрсдэлд мөн нөлөөлдөг.⁶

Тайлангийн энэ хэсэгт бид Монгол Улсын хэмжээнд хүн амын гэмт хэрэгт хохирох эрсдэлийг тооцохыг зорьж иргэдийн амьдарч байгаа орчных нь аюулгүй байдлын талаарх үзэл бодол, итгэл үнэмшлийг судалсан болно.

6. CDC, 2008a; Crandall, et al., 2004; Heise & Garcia-Moreno, 2002; Tjaden & Thoennes, 2000a

Тайлангийн дараагийн хэсэг болох хохирох эрсдэл болон хохирсон байдлын талаарх бүлгүүдэд 14 ба түүнээс дээш насны хүн амыг оролцуулсан бөгөөд цаашид энэ тайланд дурдагдах иргэд, нийт хүн ам гэсэн ойлголтыг 14 ба түүнээс дээш насны хүн амын хувьд гэж ойлгоно.

3.2.1

Амьдрах орчны нөхцөл


Хүн амьдарч буй орчиндоо гэмт хэрэг, байгалийн гамшиг, осол, эрүүл мэндийн эрсдэл зэрэг аюул заналхийллээс хамгаалагдсан, тав тухтай байх нөхцөл нь амьдрах орчны аюулгүй байдал юм. Энэ нь хувь хүний амьдралын чанарт шууд нөлөөлдөг гол хүчин зүйл мөн.

Амьдрах орчны нөхцөл байдал нь орчны эмх замбараагүй байдлаас шууд шалтгаалах бөгөөд энэ нь олон нийтийн амьдралын хэв маягийн болон биет хэлбэрийн эмх замбараагүй байдал гэсэн хоёр хүчин зүйлээс бүрддэг. Олон нийтийн амьдралын хэв маягийн эмх замбараагүй байдал нь архидан согтуурах, гудамж талбайд хэрэлдэх, зодолдох, биеэ үнэлэх, хууль бусаар архи тамхи борлуулах зэрэг нийтэд хор уршигтай үйлдэл, үзэгдлийг хэлнэ. Харин биет хэлбэрийн эмх замбараагүй байдалд хог хаягдал, эзэнгүй байр, авто зогсоол, зоорийн давхар, эвдэрсэн гэрэлтүүлэггүй орчин, граффити бичиглэл, зураг зэрэг нийтийн дунд эмх цэгцгүй байдлыг бий болгогч зүйлсийг хамруулан үздэг. Хүрээлэн буй орчны эмх замбараагүй байдал, амьдралын буруу хэв маяг нь олон нийтийн дунд гэмт хэрэг, зөрчлийн гаралт, иргэдийн гэмт хэргээс айх айдсын хүчин зүйлийг бий болгох, нэмэгдүүлэх шалтгаан нөхцөл болдог байна. Ийм учраас судалгаанд хамрагдсан иргэдээс дээрх нөхцөл байдлын талаарх үзэл бодол, итгэл үнэмшлийг асууж тодруулсан болно. Мөн зөвхөн аймгийн төв, нийслэлд амьдардаг иргэдээс авто машины зогсоол, хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламж, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан орц, гарц гэх мэт амьдрах орчны таатай нөхцөлийг хангадаг эсэхийг асууж санал бодлыг судалсан.

Нийслэлийн иргэдийн 50.4 хувь нь амьдрах орчны таатай нөхцөл хангагдаагүй гэсэн. Харин аймгийн төвийн иргэдийн 61.7 хувь нь амьдрах орчны таатай нөхцөл хангагдсан гэж үзсэн байна. Үр дүнгээс харахад нийслэлд хүн таатай амьдрах нөхцөл бусад байршилтай харьцуулахад муу байна гэж дүгнэж болохоор байна.

Зураг 8.


Амьдрах орчны таатай нөхцөл байдал, байршлаар



Амьдрах орчны таатай нөхцөлийг хангадаг гэж үздэг эсэхэд хүйсийн ялгаа байхгүй байна. Нийт иргэдийн 3.9 хувийг үйлдлийн чадварын хүндрэлтэй иргэд эзэлж байгаа бөгөөд тэдгээрийн 41.4 хувь нь амьдрах орчин нь таатай нөхцөл хангадаггүй гэжээ.

Зураг 9.

Амьдрах орчны таатай нөхцөл байдал, хувиар



Сууцны нөхцөл нь амьдрах орчны аюулгүй байдлыг тодорхойлох чухал хүчин зүйл юм. Стандарт хангаагүй эрсдэлтэй сууцанд амьдрах нь гэмт хэрэг, осол, эрүүл мэндийн эрсдэлд өртөх магадлалыг нэмэгдүүлдэг бол сайн нөхцөлтэй сууц нь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх болон сэтгэл санааны тайван байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэх нь дамжиггүй. Судалгаанаас харахад амьдрах орчны таатай нөхцөл хангагдсан гэж үздэг эсэх нь өрхийн сууцны төрлөөс хамааран ялгаатай байна. Тухайлбал, бие даасан тохилог сууцанд амьдардаг иргэдийн 83.3 хувь амьдрах орчны таатай нөхцөл нь хангагдсан гэж үзсэн бол орон сууцны байшин, гэр, сууцны тусдаа байшинд амьдардаг иргэдийн тал хувь нь буюу 52.3-55.3 хувь нь амьдрах орчны таатай

нөхцөл хангагдсан гэж тодорхойлсон байна. Харин зориулалтын бус сууцанд амьдардаг иргэдийн 77.4 хувийн амьдрах орчны таатай нөхцөл хангагдаагүй байна.

Зураг 10.

Амьдрах орчны таатай нөхцөл байдал, сууцны төрлөөр, хувиар

Нийслэлд амьдардаг иргэдийн 50.6 хувь нь тогтоосон эрх зүйн хэм хэмжээ, хууль, дүрэм, журам зөрчдөг олон хүн байдаг гэж хариулсан бол аймгийн төв (63.9 хувь), сумын төв (66.2 хувь), хөдөөгийн иргэдийн (75.5 хувь) дийлэнх нь тогтоосон эрх зүйн хэм хэмжээ, хууль, дүрэм, журам зөрчдөг хүн олон байдаггүй гэдгээ илэрхийлсэн байна. Нөгөөтэйгүүр олон нийтийн амьдралын хэв маягийн эмх замбараагүй байдлын нэг үзэгдэл болох хууль бусаар архи, тамхи худалдаалдаг айл, дэлгүүр, ТҮЦ, иргэд байдаг эсэх талаар асуухад бүх байршилд амьдарч буй иргэдийн дийлэнх нь (69.2-83.5 хувь) байдаггүй гэж хариулсан байна. Өрхийн амьдарч буй сууцны төрлөөр авч үзвэл орон сууцанд амьдардаг иргэд бусад төрлийн сууцанд амьдардаг иргэдтэй харьцуулахад өндөр буюу арван иргэн тутмын 5 нь тогтоосон эрх зүйн хэм хэмжээ, хууль, дүрэм, журам зөрчдөг олон хүн байдаг гэдгийг илэрхийлсэн байна. Энэ нь орон сууцны байшинд амьдрах нэг сул талыг илэрхийлж байж магадгүй үзүүлэлт бөгөөд хөршүүд ойрхон амьдрах нь дуу чимээ, хөл хөдөлгөөн их байх, эрүүл ахуйн дэглэм сахихгүй байх, нийтийн өмч болох орц, цахилгаан шат зэрэг орон зайн ашиглалт муу байх зэрэг олон асуудлыг дагуулдаг болохыг харуулж байх талтай.

Биет хэлбэрийн эмх замбараагүй байдал иргэдийн амьдрах орчны нөхцөл байдалд хэрхэн нөлөө үзүүлж байгаа талаар судалсан бөгөөд иргэдийн 53.5 хувь нь оршин суугаа газар нь орчны бохирдол, хог хаягдал ихтэй гэж хариулсан байна. (Хавсралт. Хүснэгт 1.3)

Нийслэлийн арван иргэн тутмын 7, үүнээс ажил эрхэлдэг арван иргэн тутмын 6 нь замын түгжрэл ихтэй газар амьдарч байна. (Хавсралт. Хүснэгт 1.5)

Замын түгжрэл нь хүний өдөр тутмын амьдралын чанар, цаг ашиглалт, эрүүл мэндэд шууд байдлаар нөлөөлж байна. Тухайлбал, хүний чөлөөт цагийг багасган нийгмийн харилцааны чанарт муугаар нөлөөлөх, стрессийг нэмэгдүүлэн амьдралын сэтгэл ханамжийг бууруулах, агаарын бохирдол үүсгэн эрүүл мэндэд муугаар нөлөөлөх зэрэг сөрөг үр дагавар ихтэй учраас замын түгжрэл нь зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай асуудлын нэг гэдэг нь тодорхой юм. Ялангуяа нийслэл хотын замын түгжрэлийн асуудал иргэдийн амьдрах орчны аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлдэг хамгийн том хүчин зүйлийн нэг болсоор байна.

Эзэнгүй муур, нохой элбэг байх нь амьдрах орчны аюулгүй байдалд хамааралтай гэж үзэн асуулгад оруулсан бөгөөд арван иргэн тутмын 7 нь эзэнгүй муур, нохой элбэг орчинд амьдардаг гэж хариулсан байна. Суурьшлаар харвал аймгийн төв болон сумын төвд (81.6, 79.3 хувь) эзэнгүй муур, нохой элбэг байна.

Үер, усанд автах эрсдэл, аюул нь амьдрах орчны нөхцөл байдал, аюулгүй байдлын чухал асуудал бөгөөд энэхүү судалгаагаар энэ аюулын иргэдийн амьдралын чанарт нөлөөлөх нөлөөлөл, эрсдэлийн талаарх иргэдийн санал бодлыг судалсан юм. Энэ хариултын хувьд иргэдийн нас, хүйс, амьдарч байгаа байршил, сууцны төрлөөс хамаарсан ялгаатай байдал ажиглагдаагүй бөгөөд гэр, сууцны тусдаа байшинд амьдардаг арван иргэн тутмын 3 нь л амьдарч байгаа газар нь үер, усанд автах эрсдэлтэй гэдэгтэй санал нийлнэ буюу эрсдэлтэй гэж үзжээ.

Хүснэгт 5.**Оршин сууж байгаа газрын нөхцөл байдал, байршлаар, сууцны төрлөөр, хувиар**

Оршин сууж байгаа газар нь		Бүгд	Байршил				Сууцны төрөл					
			Нийслэл	Аймгийн төв	Сумын төв	Хөдөө	Гэр	Орон сууцны байшин	Бие даасан тохилог сууц	Сууцны тусдаа байшин	Нийтийн байр (ажилчдын, оюутны, бусад)	Зориулалтын бус сууц
Орчны бохирдол хог хаягдал ихтэй	Тийм	53.5	62.6	55.7	43.9	34.9	42.4	60.5	50.0	56.8	59.4	39.8
	Үгүй	46.0	36.8	43.7	55.7	64.9	57.3	39.0	50.0	42.6	40.6	60.2
	Мэдэхгүй / Хариулаагүй	0.5	0.6	0.6	0.3	0.2	0.4	-	-	0.7	-	-
Эзэнгүй орхигдсон хашаа, саравч, байшин, зоорийн давхар, хүн орогнох боломжтой хаягдал автомашин, зогсоол, траншейн, гуу жалга гэх мэт зүйлс байдаг.	Тийм	27.8	30.9	27.8	30.0	19.7	25.4	24.2	33.3	33.3	29.8	17.9
	Үгүй	68.8	64.1	69.0	68.0	79.6	72.9	71.4	66.7	62.6	69.1	77.6
	Мэдэхгүй / Хариулаагүй	3.4	5.0	3.3	2.0	0.7	1.7	4.4	-	4.1	1.1	4.5
Тогтоосон эрх зүйн хэм хэмжээ, хууль, дүрэм, журам зөрчдөг хүн олон байдаг.	Тийм	38.2	50.5	31.2	29.5	21.6	27.8	48.5	16.7	37.9	37.2	34.1
	Үгүй	57.2	44.3	63.9	66.2	75.5	68.7	46.4	83.3	57.0	61.8	62.9
	Мэдэхгүй / Хариулаагүй	4.5	5.1	4.9	4.3	2.9	3.5	5.1	-	5.1	1.0	3.0
Бүлэглэн танхайрах явдал ажиглагддаг	Тийм	21.7	29.4	18.7	16.2	9.8	14.6	29.4	33.3	20.6	24.5	32.4
	Үгүй	75.3	66.4	78.8	81.3	89.0	83.2	66.9	66.7	76.1	74.7	67.6
	Мэдэхгүй / Хариулаагүй	3.1	4.2	2.6	2.5	1.2	2.2	3.7	-	3.3	0.8	-
Согтуу мансуурсан, чанга дуугаар хэрэлдэж эсвэл зодолдож байгаа хүмүүсийг байнга хардаг	Тийм	39.1	50.3	34.0	31.9	22.1	28.8	50.2	16.7	37.7	40.0	52.7
	Үгүй	59.5	47.8	64.5	66.7	77.3	70.4	48.1	83.3	60.5	60.0	47.3
	Мэдэхгүй / Хариулаагүй	1.5	1.9	1.5	1.4	0.6	0.9	1.7	-	1.8	-	-
Эзэнгүй нохой муур, ихтэй	Тийм	68.5	68.4	81.5	79.3	50.2	60.4	63.5	83.3	80.1	84.6	73.8
	Үгүй	30.5	30.4	17.5	20.1	49.4	39.1	35.0	16.7	19.0	15.4	26.2
	Мэдэхгүй / Хариулаагүй	0.9	1.2	1.0	0.5	0.4	0.5	1.5	-	0.9	-	-
Хууль бусаар архи тамхи худалдаалдаг айл, дэлгүүр, ТҮЦ, иргэд байдаг	Тийм	12.5	14.4	9.4	16.4	9.7	9.8	13.6	-	13.9	12.6	23.0
	Үгүй	74.3	69.2	76.9	73.1	83.5	80.1	73.5	33.3	69.7	79.0	69.4
	Мэдэхгүй / Хариулаагүй	13.2	16.3	13.7	10.5	6.8	10.1	12.9	66.7	16.4	8.4	7.6

Уул уурхайн олборлолт, эрдэс бодисын үйлдвэр болон хүнд үйлдвэрлэл нь иргэдийн амьдрах орчны аюулгүй байдалд ялангуяа орон нутгийн иргэдийн амьдралд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл ихтэй учраас энэ чиглэлийн тодруулах асуултыг асуулгад оруулсан болно. Сумын төвийн иргэдийн 68.4 хувь, хөдөөгийн иргэдийн 81.6 хувь амьдарч байгаа газарт нь хүнд үйлдвэрлэл, уул уурхай ашигт малтмал олборлолтын улмаас байгаль, экологийн тэнцвэрт байдал алдагдсан гэж хариулсан. Харин Баруун бүсийн иргэдийн 84.6 хувь уул уурхай ашигт малтмал олборлолтын улмаас байгаль, экологийн тэнцвэрт байдал алдагдсан гэж хариулсан нь бусад бүстэй харьцуулахад өндөр үзүүлэлт байв.

Хүснэгт 6.

Уул уурхайн олборлолт, эрдэс бодисын үйлдвэр болон хүнд үйлдвэрлэлийн улмаас оршин сууж байгаа газрын байгаль, экологийн тэнцвэрт байдал алдагдсан эсэх, бүс, байршлаар, дүнд эзлэх хувиар


		Байршил		Бүс			
		Сумын төв	Хөдөө	Баруун	Хангай	Төв	Зүүн
Уул уурхай ашигт малтмал олборлолтын улмаас байгаль, экологийн тэнцвэрт байдал алдагдсан гэж үздэг	Тийм	68.4	81.6	84.6	70.2	76.7	71.9
	Үгүй	24.2	12.0	11.8	16.1	17.8	20.6
	Мэдэхгүй/ Хариулаагүй	7.4	6.4	3.6	13.7	5.5	7.5

Малын бэлчээрийн даацын асуудал нь өрхийн амьдрах нөхцөлд шууд болон шууд бус байдлаар нөлөө үзүүлдэг. Даац хэтэрсэн үед бэлчээр талхлагдаж, ургамлын шим тэжээл буурч улмаар мах, сүүний гарц багасах зэргээр малаас авах ашиг шимд сөрөг нөлөө үзүүлэхээс гадна малдаа нэмэлт тэжээл худалдан авах гэх мэтчилэн малчид зардлаа нэмэгдүүлэх замаар алсдаа амьжиргаанд нь сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй. Цаашлаад байгаль экологийн тэнцвэрт байдал алдагддаг байна. Бид энэ асуудлыг хөндөх үүднээс судалгаанд хамрагдсан сумын төвийн болон хөдөөгийн иргэдээс малын бэлчээрийн даац хэтэрсэн эсэх, хэтэрсэн бол амьдралынх нь хэв маяг, амьжиргааны түвшинд хэрхэн нөлөөлснийг асууж судалсан болно.

Судалгаагаар сумын төвийн иргэдийн 58.7 хувь, хөдөөгийн иргэдийн 70.5 хувь нь малын бэлчээрийн даац хэтэрсэн гэж хариулсан байна. Түүнчлэн бүсээр авч үзвэл Баруун бүсийн хувьд хамгийн өндөр буюу арван иргэн тутмын 7 нь малын бэлчээрийн даац хэтэрсэн гэж үзжээ. Иргэдийн хариултаас харахад малын бэлчээрийн даацын асуудал хөдөө орон нутгийн хувьд хамгийн тулгамдсан асуудал болсон нь тодорхой байна.


Зураг 11.

Малын бэлчээрийн даацын нөхцөл байдал, байршлаар, хувиар



Зураг 12.

Малын бэлчээрийн даацын нөхцөл байдал, бүсээр, хувиар



3.2.2

Иргэд хоорондын харилцаа, иргэдийн цагдаагийн байгууллагад итгэх итгэл

Аливаа гэмт хэрэг гарахаас, гэмт хэрэгт хохирох эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд иргэд хоорондын харилцаа чухал бөгөөд үүнийг олон нийтийн хяналтаар хэмждэг. Олон нийтийн хяналт сулрахад амьдрах орчинд эмх замбараагүй байдал бий болдог учир энэхүү судалгаагаар иргэд хоорондоо хэрхэн харилцаж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд яаж хамтарч ажилладаг талаар мэдээлэл цуглуулах гэж зорилоо.


Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд иргэд хоорондын харилцааны үүрэг чухал бөгөөд нийгмийн аюулгүй байдлыг хангахад иргэн бүрийн идэвхтэй оролцоо шаардлагатай байдаг. Түүнчлэн иргэд хоорондын эерэг харилцаа нь итгэлцэл, хариуцлага, хамтын ажиллагааг бий болгож, гэмт хэргийн эрсдэлийг бууруулахад томоохон хувь нэмэр оруулах боломжтой юм.

Сайн хөршийн харилцаа нь гэмт хэргийн сэжигтэй үйлдлийг мэдээлэх, таслан зогсоох, хурдан илрүүлэх боломжийг нэмэгдүүлдэг төдийгүй эрсдэлийг бууруулдаг. Судалгаагаар бид иргэдийн хөрш болон саахалт айлын хүмүүсээ таньдаг эсэх талаар асуусан бөгөөд арван хүн тутмын 6 нь хөрш болон саахалт айлын хүмүүсээ сайн мэддэг гэсэн хариулт өгсөн нь эерэг үзүүлэлт юм. Гэхдээ энэ үзүүлэлт байршлаар нэлээд ялгаатай байна. Тухайлбал, нийслэлийн иргэдийн 40.6 хувь нь хөрш болон саахалт айлын хүмүүсээ сайн мэддэггүй гэсэн бол сумын төвийн иргэдийн 89.2 хувь, хөдөөгийн иргэдийн 92.2 хувь нь хөрш болон саахалтын айлын хүмүүсээ сайн мэддэг гэв.

Мөн хөрш болон саахалт айлын хүмүүсээ сайн мэддэг эсэх нь өрхийн амьдардаг сууцны төрлөөр нэлээд ялгаатай байна. Тухайлбал, бие даасан тохилог сууц буюу хауст амьдардаг иргэд бүгд хөршөө сайн мэддэг гэсэн бол нийтийн байр, зориулалтын бус сууц, орон сууцны байшинд амьдардаг иргэдийн 12.0-39.5 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байгаа нь магадгүй эдгээр сууцны төрөлд түрээсэлж амьдардаг иргэд их байдагтай холбоотой байж болох талтай.

Зураг 13.


Хөрш болон саахалт айлын хүмүүсээ сайн мэддэг эсэх, сууцны төрлөөр, байршлаар, хувиар



Хөршийн сайн харилцаа гэдэг нь хөрш болон саахалт айлын хүмүүс ямар нэгэн асуудал, хүндрэл үүссэн үед нэгэндээ туслалцаа үзүүлдэг, бусдын халдлагад өртөж буй хүүхдэд туслалаар бэлэн байдаг болон гэмт хэргийг харсан даруйдаа цагдаагийн байгууллагад мэдээлэл өгдөг иргэдийн хувийг харуулж байгаа бөгөөд сумын төвд амьдардаг иргэдийн 74.7 хувь хөршийн сайн харилцаатай байгаа бол нийслэлийн хувьд 43.7 хувьтай байна. Мөн уг үзүүлэлтийг сууцны төрлөөр авч үзвэл бие даасан тохилог сууц буюу хауст амьдардаг иргэд хамгийн сайн хөршийн харилцаатай байдаг бол орон сууцны байшинд амьдардаг иргэдийн хөршийн харилцаа хамгийн муу байна.

Зураг 14.

Хөршийн сайн харилцаа, сууцны төрлөөр, байршлаар, хувиар



Цагдаагийн байгууллага болон иргэдийн итгэлцэл нь нийгмийн аюулгүй байдал, хууль сахиулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэдэг. Цагдаагийн байгууллага иргэдийн итгэлийг олж авах нь олон хүчин зүйлээс хамаардаг бөгөөд энэ итгэлцэл нь нийгэм дэх гэмт хэргийн түвшинг бууруулах, хууль зөрчигчдийг илрүүлж, тэдэнд хариуцлага тооцох зорилгоор ажилладаг. Энэ судалгаагаар иргэдийн цагдаагийн байгууллагад итгэх итгэл болон тэдний талаарх үзэл бодлыг асуусан. Нийт иргэдийн 48.9 хувь нь цагдаагийн байгууллага болон цагдаагийн албан хаагч хариуцсан нутаг дэвсгэртээ эргүүлийн үйл ажиллагааг маш сайн гүйцэтгэдэг гэсэн бол 49.2 хувь нь иргэдээс хүлээн авсан гомдол, мэдээллийг түргэн шуурхай шийдвэрлэдэг гэсэн байна. Харин нийт иргэдийн 67.0 хувь нь цагдаа бидний аюулгүй байдлыг сахин хамгаалж чадна гэж үзэл бодлоо илэрхийлжээ.

Хүснэгт 7.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн үзэл бодол, байршлаар, хувиар

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн хандлага		Байршил				Улсын дүн
		Нийслэл	Аймгийн төв	Сумын төв	Хөдөө	
Хариуцсан нутаг дэвсгэртээ эргүүлийн үйл ажиллагааг маш сайн гүйцэтгэдэг	Тийм	39.2	55.7	62.3	57.8	48.9
	Үгүй	50.0	29.6	25.7	32.9	39.6
	Мэдэхгүй / Хариулаагүй	10.8	14.7	12.0	9.3	12.0

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн хандлага		Байршил				Улсын дүн
		Нийслэл	Аймгийн төв	Сумын төв	Хөдөө	
Иргэдээс хүлээн авсан гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийг хуулийн дагуу хурдан шуурхай шалгаж шийдвэрлэдэг.	Тийм	46.4	48.8	55.4	53.4	49.2
	Үгүй	37.8	27.5	25.8	28.5	32.5
	Мэдэхгүй / Хариулаагүй	15.8	23.7	18.8	18.1	18.0
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах мэдлэг, чадвартай	Тийм	57.2	60.6	63.3	65.0	60.9
	Үгүй	30.8	21.3	19.3	21.0	24.3
	Мэдэхгүй / Хариулаагүй	12.0	18.1	17.4	14.0	14.8
Албан үүргээ гүйцэтгэхдээ иргэдтэй соёлтой, ёс зүйтэй харилцдаг.	Тийм	49.7	55.8	64.7	64.8	57.2
	Үгүй	41.1	29.3	23.5	23.9	31.2
	Мэдэхгүй / Хариулаагүй	9.2	14.9	11.8	11.3	11.6
Цагдаа та бидний аюулгүй байдлыг хангаж чадна гэдэгтэй санал нийлнэ.	Тийм	62.0	69.3	72.8	73.4	67.0
	Үгүй	32.3	21.1	18.4	19.6	25.9
	Мэдэхгүй / Хариулаагүй	5.7	9.6	8.8	7.0	7.1

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэдийн гэмт хэргийн талаарх үзэл бодол чухал нөлөө үзүүлдэг гэж үздэг бөгөөд иргэдийн үзэл бодол болон төсөөллийн асуултыг энэ судалгаагаар цуглуулсан болно. Бид гэмт хэргийн гаралтын цаашдын чиг хандлагыг улсын хэмжээнд болон оршин сууж буй нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрхэн өөрчлөгдөх талаар иргэдийн үзэл бодлыг нь асуусан. Гэмт хэргийн гаралтын талаарх иргэдийн төсөөлөл нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгт хохирох эрсдэлээс сэрэмжлэхэд эерэг нөлөөтэй ч нөгөө талаас иргэдийн гэмт хэргээс айх айдсыг нэмэгдүүлэх сөрөг талтай байж болно.

Нийт иргэдийн 33.9 хувь нь улсын хэмжээнд гэмт хэрэг өснө гэсэн төсөөлөлтэй байгаа бөгөөд нийслэлийн иргэдийн хувьд гэмт хэргийн гаралт хамгийн ихээр өснө гэж хариулжээ. Харин оршин сууж буй нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд бүх байршлын иргэдийн арван хүн тутмын 7-8 нь гэмт хэргийн гаралтыг цаашид буурна эсвэл хэвэндээ байна гэж үзжээ.

Хүснэгт 8.


Гэмт хэргийн гаралтын өөрчлөлтийн талаарх иргэдийн төсөөлөл, хувиар

Гэмт хэргийн гаралт	Буурна	Хэвэндээ байна	Өснө	Мэдэхгүй/ Хариулаагүй
Улсын хэмжээнд	22.8	27.0	33.9	16.4
Нийслэл	21.0	25.5	38.8	14.7
Аймгийн төв	24.9	24.6	30.6	19.9
Сумын төв	19.2	29.1	30.4	21.3
Хөдөө	26.3	31.8	27.8	14.1
Оршин сууж буй нутаг дэвсгэрийн хэмжээнд	28.9	41.7	12.8	16.5
Нийслэл	27.0	40.6	14.8	17.6
Аймгийн төв	30.2	35.2	14.7	19.9
Сумын төв	25.5	47.8	9.4	17.2
Хөдөө	33.5	48.5	7.9	10.1

Улсын хэмжээнд гэмт хэргийн гаралт нэмэгдэнэ гэж төсөөлж байгаа иргэд нь оршин сууж буй нутаг дэвсгэрт гэмт хэргийн гаралт өснө гэж хариулсан иргэдээс 2.6 дахин их байгаа бөгөөд тэд гэмт хэргийн гаралтын өсөх гол шалтгаан нь архидалт, ажилгүйдэл, ядуурал гэж үзсэн байна.

Зураг 15.

Гэмт хэргийн гаралт өсөх шалтгаан, улсын болон оршин сууж буй нутаг дэвсгэрийн хэмжээнд, хувиар



3.2.3

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай иргэдийн үзэл бодол

Иргэдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай үзэл бодол нь олон талт бөгөөд энэ нь тухайн нийгэм, улс орны соёл, эдийн засаг, хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаа, хүмүүсийн сэтгэл зүй зэрэг олон хүчин зүйлсээс хамаарна. Тэдний үзэл бодол нь нийгмийн аюулгүй байдал, хүмүүсийн амьдрах орчин, хамтран амьдрах соёл, хуулийн байгууллагын үүрэг гүйцэтгэх чадвараас шууд хамааралтай гэж мөн үздэг. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ерөнхий хандлага нь иргэд өөрсдийгөө гэмт хэргийн хохирогч болж болзошгүй гэсэн хариу үйлдэл боловч ийм мэдрэмж төрж байгаа нь амьдарч буй орчны нөхцөл байдалтай шууд холбоотой байдаг. Тиймээс амьдралын ямар хэв маягтай байх нь хохирогч болох магадлалыг нэмэгдүүлэх вэ гэдгийг ойлгох нь тун чухал юм. Энэ хэсэгт бид иргэдийн гэмт хэргийн талаарх үзэл бодлоос гадна тэдний айдсын мэдрэмжийг тоон дүнгээр харуулах гэж зорилоо.

Иргэдийн дийлэнх хувь нь үдэш, шөнө гэртээ ганцаараа байхад аюулгүй санагддаг гэдгээ илэрхийлсэн ч хүйс, байршил, сууцны төрлөөс хамааран бага зэрэг ялгаатай байна. Тодруулбал, эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 2.5 дахин илүү аюул, айдсын мэдрэмж авдаг. Мөн нийслэлд амьдардаг иргэд болон зориулалтын бус сууц, гэрт, сууцны тусдаа байшинд амьдардаг иргэдэд аюул, айдсын мэдрэмж илүү төрдөг байна.

Хүснэгт 9.

Үдэш, шөнийн цагаар гэртээ ганцаараа байхад аюулгүй санагддаг эсэх, хүйс, байршлаар, сууцны төрөл, хувиар


Үзүүлэлт	Аюултай	Аюулгүй	Мэдэхгүй/ Хариулаагүй
Хүйс			
Эрэгтэй	7.1	92.0	0.9
Эмэгтэй	17.7	81.1	1.2
Байршил			
Нийслэл	14.9	83.7	1.4
Аймгийн төв	11.1	88.0	0.9
Сумын төв	10.1	88.7	1.2
Хөдөө	12.0	87.7	0.3
Сууцны төрөл			
Гэр	14.6	84.5	0.8
Орон сууцны байшин	9.6	89.5	0.9
Бие даасан тохилог сууц	0.0	100.0	-
Сууцны тусдаа байшин	14.9	83.7	1.4
Нийтийн байр (ажилчдын, оюутны, бусад)	8.7	90.2	1.0
Зориулалтын бус сууц	18.2	81.8	-

Сургууль, сургуулийн орчинд болон бусад олон нийтийн газруудад хэр зэрэг аюулгүй санагддаг талаарх иргэдийн үзэл бодлыг судлахад иргэдийн олонх нь олон нийтийн газарт аюулгүй гэсэн хариулт өгсөн хэдий ч эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү аюул, айдсын мэдрэмжийг авсаар байна. Энэ нь эмэгтэйчүүд нийгмийн амьдралд оролцохдоо илүү айдастай байдгийг илэрхийлэх бөгөөд эмэгтэйчүүд, хүүхдүүдэд ээлтэй айдасгүй, аюулгүй орчинг бий болгох нийгмийн шаардлага байгааг судалгааны үр дүн харуулж байна.

Сургуулийн орчинд аюулгүй санагддаг эсэхийг байршлаар харахад төвлөрсөн хот суурин газраас алслагдах тусам буюу төвлөрөл багасахад аюулгүй гэж хариулсан хариулт нэмэгдсэн байна. Нийслэлийн иргэдийн 41.4 хувь нь сургуулийн орчинг аюултай гэж дүгнэсэн бол аймгийн төвд 24.2 хувь, сумын төвийн иргэдийн 17.1 хувь, хөдөө амьдардаг иргэдийн 15.5 хувь нь тус тус сургуулийн орчинг аюултай гэж хариулжээ.

Зураг 16.


Сургуулийн орчинд аюулгүй санагддаг эсэх, байршлаар, хувиар



Сургуулийн орчин аюулгүй санагддаг эсэхийг насны бүлгээр харахад 30-34 настай иргэд илүүтэйгээр сургуулийн орчинг аюултай орчин гэж хариулсан бол 14-17 насныхны 78.5 хувь сургуулийнхаа орчинг аюулгүй гэж үзсэн нь хамгийн өндөр хувьтай байна. Сургуулийн орчин аюулгүй гэж арван хүүхэд тутмын 8 нь үзэж байгаа нь эерэг үзүүлэлт хэдий ч арван хүүхэд тутмын 2 нь сургуулийн орчин аюултай гэж үзсэн нь мөн анхаарахгүй өнгөрч болохгүй тоон үзүүлэлт юм. Сургуулийн орчинг аюулгүй, айдасгүй болгосноор хүүхдүүд сэтгэл санааны хувьд илүү тайван байх, амжилттай суралцах, сэтгэц болон биеийн эрүүл мэндийн хувьд ч дэмжигдсэн байдалтай өсч хөгжих боломжтой юм. Мөн аюулгүй орчин нь хүүхэд, залуусын хоорондын харилцааг сайжруулж, хүчирхийлэл болон бусад сөрөг үйлдэл гарах нөхцөлийг бууруулна.

Зураг 17.


Сургуулийн орчинд аюулгүй санагддаг эсэх, насны бүлгээр, хувиар



Мөн иргэдээс олон нийтийн газар (худалдаа, үзвэр үйлчилгээ, цэцэрлэгт хүрээлэн, амралт зугаалгын газар, гудамж талбай гэх мэт)-т аюулгүй санагддаг эсэхийг судлахад хүн ам хамгийн их төвлөрсөн газар буюу нийслэлд оршин суудаг иргэдийн арван хүн тутмын 3 нь олон нийтийн газрыг аюултай, гэмт хэрэгт хохирох эрсдэлтэй газрууд гэж хариулсан нь хамгийн өндөр үзүүлэлт байна.

Зураг 18.

Олон нийтийн газар аюулгүй санагддаг эсэх, байршлаар, хувиар



Үүнээс гадна нийтийн тээврийн хэрэгслээр зорчиход аюултай санагддаг гэж нийслэлийн иргэдийн 46.0 хувь нь хариулсан байна.

3.2.4

Гэмт хэргийн хохилогч болох айдас

Гэмт хэргийн хохирогч болох айдас нь олон хүний амьдралд тодорхой хэмжээний сэтгэл зүйн дарамт учруулдаг, нийгмийн аюулгүй байдалтай холбоотой хамгийн түгээмэл айдас юм. Өөрөөр хэлбэл гэмт хэргээс айх айдсыг бие махбодод гэмтэл учруулах аюулаас үүдэлтэй айдас, түгшүүрийн мэдрэмж гэж тодорхойлж болно. Иргэдийн гэмт хэргийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэхийн тулд зөв мэдээлэл өгөх, өөрийгөө хамгаалах ур чадварыг эзэмшүүлэх, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх зэргээр гэмт хэргийн хохирогч болох айдсыг бууруулах боломжтой байдаг.

Гэмт хэргээс айх айдас нь амьдралын чанарт сөргөөр нөлөөлж, амьдарч байгаа нутгаасаа явах, өдөр тутмын үйл ажиллагаагаа хязгаарлах, гэр орноо болон өөрийгөө хамгаалахын тулд зэвсэг авч явах зэрэг байнгын түгшүүр, зан үйлийн өөрчлөлтөд хүргэдэг тул бодлого боловсруулагчдын хувьд нийгмийн чухал асуудал юм (Ферраро , 1995, Уорр, 1985). Иргэд гэмт хэргийн хохирогч болохоос болгоомжилдог бөгөөд үүнээс үүдэн тэдний өдөр тутмын амьдралд ямар нэг хэмжээгээр айдас бий болдог байна.

Энэхүү судалгаагаар бид тодорхой төрлийн гэмт хэргээс айх айдсын талаарх мэдээллийг нэгтгэж харуулахыг зорилоо.

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгтэй холбоотой айдсыг мөнгө, үнэт здлэл, эд хөрөнгийг хулгайлна, залилан мэхэлж авна, санаатай устгаж, гэмтээнэ гэж хэн нэгнээс айх айдсын хариултаар нэгтгэн тодорхойлов.

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч болохоос айдаг иргэд нийслэлд хамгийн өндөр буюу 61.9 хувийг эзэлж байна. Харин сумын төвийн иргэд харьцангуй айдас багатай байна. Сууцны төрлийн хувьд ялгаа ажиглагдахгүй бүгд жигд айдастай бөгөөд гэр болон нийтийн байранд амьдардаг иргэдийн айдас бага байх хандлагатай.

Зураг 19.

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт өртөнө гэж айдаг хүн ам, хувиар



Хүчирхийллийн шинжтэй үйлдэлтэй холбоотой айдсыг мөнгө, үнэт, эдлэл, эд хөрөнгийг хүч хэрэглэж авна, амь нас, эрүүл мэндэд халдана, хохирооно, орон байранд хууль бусаар нэвтрэнэ, мөшгинө эсвэл утсаар дарамтад оруулна гэж хэн нэгнээс айх айдсын хариултаар нэгтгэн тодорхойлов.

Судалгаагаар иргэдийн дунд хэн нэгэн хүчирхийлэгчийн зүгээс орон байранд нь хууль бусаар нэвтрэх, эд хөрөнгийг нь хүч хэрэглэн авах, амь нас, эрүүл мэндэд халдаж хохироох, мөрдөж мөшгих, сэтгэл санааны дарамтад оруулах вий гэсэн айдас тодорхой хэмжээнд байдаг нь харагдаж байна. Ялангуяа хэн нэгэн хүчирхийлэгч оронд байранд нь хууль бусаар нэвтрэх орох вий, амь нас, эрүүл мэндэд минь халдаж хохироох вий гэсэн айдас илүү давамгайлах шинжтэй байна.

Зураг 20.


Хүчирхийллийн шинжтэй үйлдэлтэй холбоотой айдас, дүнд эзлэх хувиар



Нөгөө талаас иргэдийг тэр дундаа эмэгтэйчүүдийг айдаст автоулдаг нэг зүйл нь бэлгийн хүчирхийлэл юм. Үр дүнгээс харвал 14 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн 35.2 хувь нь хэн нэгний бэлгийн хүчирхийлэлд өртөхөөс айдаг гэж хариулжээ.

Зураг 21.


Бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой айдас, хүйсээр, хувиар



Бэлгийн хүчирхийлэлд өртөхөөс айх айдас нь нийслэл, аймгийн төвийн иргэдийн хувьд бусад байршлаас өндөр буюу 30.9, 23.3 хувь байна. Хүн ам төвлөрсөн хот суурин газарт бэлгийн хүчирхийллийн хохирогч болох магадлал өсдөг нь энэ айдсыг нэмэгдүүлсэн байх боломжтой юм. Цаашдаа бэлгийн хүчирхийллийг таслан зогсоохын тулд хуулийн хэрэгжилтийг сайжруулах, хүчирхийллийн хохирогч болохгүй байх мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх, хохирогчийг хамгаалах цогц үйлчилгээг нэвтрүүлэх зэрэг асуудлыг шийдвэрлэх нь чухал алхам болно.

Зураг 22.

Бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой айдас, дүнд эзлэх хувиар



Иргэд гэмт хэрэгт хохирохоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор өөрийгөө болон гэр бүлийн гишүүдээ мөн эд хөрөнгөө хамгаалах үйлдлийг хийдэг. Энэ үйлдлийг идэвхтэй болон идэвхгүй гэж ангилж үзнэ.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх идэвхтэй үйлдэл гэдгийг өөрийгөө хамгаалах зорилгоор бие хамгаалах болон дохио өгөх ямар нэгэн хэрэгсэл авч явдаг, оршин сууж буй нутаг дэвсгэртээ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ямар нэгэн ажил сайн дураараа хийдэг болон гэрээсээ хол явах тохиолдолд хөрш болон саахалт айлаасаа гэрээ харж байхыг хүсдэг гэж хариулсан иргэдийн хариултаар тодорхойлно.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх идэвхгүй үйлдэл гэдэг үзүүлэлтэд унтахаасаа өмнө хаалга, цонхоо шалгадаг, оройн цагаар гадуур гарахдаа хэн нэгнээс хамт явах талаар тусламж хүсдэг, хохирогч болохгүй байх үүднээс аюултай газраар явахаас зайлсхийдэг болон оройн цагаар ганцаараа такси барихаас зайлсхийдэг зэрэг орно.

Нийслэлийн хувьд нийт иргэдийн 32.5 хувь гэрээсээ хол явах тохиолдолд хөрш болон саахалт айлаасаа гэрээ харж байхыг хүсдэг бол хөдөөгийн иргэдийн 76.0 хувь нь гэрээсээ хол явах тохиолдолд хөршөөсөө гэрээ харж байхыг хүсдэг байна. Нийслэлд амьдардаг иргэдийн 81.5 хувь унтахаасаа өмнө хаалга, цонхоо шалгадаг гэж хариулсан бол хөдөөд 65.1 хувь байна. Эрэгтэйчүүдийн 83.0 хувь нь оройн цагаар гадуур гарахдаа хэн нэгнээс хамт явах талаар тусламж хүсдэггүй гэж хариулсан бол эмэгтэйчүүдийн хувьд 49.8 хувь нь оройн цагаар гадуур гарахдаа хэн нэгнээс хамт явах талаар тусламж хүсдэг байна. Харин гэмт хэргээс урьдчилан сэргийлэх идэвхтэй үйлдлийн нэг болох өөрийгөө хамгаалах зорилгоор бие хамгаалах болон дохио өгөх ямар нэгэн хэрэгсэл авч явдаг иргэд улсын дунджаар 8.3 хувь буюу бага үзүүлэлттэй байна. Нийслэлийн иргэдийн арван хүн тутмын 1 нь өөрийгөө хамгаалах ямар нэгэн хэрэгсэл авч явдаг гэж хариулсан нь бусад байршилтай харьцуулахад өндөр байна.

Хүснэгт 10.


Өөрийгөө хамгаалах зорилго бүхий урьдчилан сэргийлэх үйлдэл, хүйс, боловсролын түвшин, байршлаар

Үзүүлэлт	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх идэвхтэй үйлдэл			Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх идэвхгүй үйлдэл			
	Өөрийгөө хамгаалах зорилгоор бие хамгаалах болон дохио өгөх ямар нэгэн хэрэгсэл авч явдаг	Оршин сууж буй нутаг дэвсгэртээ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сайн дурын ажил хийдэг	Гэрээсээ хол явах тохиолдолд хөрш болон саахалт айлаасаа гэрээ харж байхыг хүсдэг	Унтахаасаа өмнө хаалга, цонхоо шалгадаг	Оройн цагаар гадуур гарахдаа хэн нэгнээс хамт явах талаар тусламж хүсдэг	Хохирогч болохгүй байх үүднээс аюултай газраар явахаас зайлхийдэг	Оройн цагаар ганцаараа такси барихаас зайлсхийдэг
Хүйс	Улсын дундаж	8.3	17.8	53.4	76.1	35.2	27.8
	Эрэгтэй	8.8	19.8	52.9	69.4	17.0	17.2
	Эмэгтэй	7.9	16.2	53.8	81.4	49.8	36.4
Боловсролын түвшин	Боловсролгүй	9.1	11.7	69.2	69.2	34.0	11.4
	Бага	9.6	16.8	63.8	70.8	37.4	17.1
	Суурь	8.7	16.4	58.2	72.0	36.3	24.6
	Бүрэн дунд	7.7	16.9	56.1	75.6	33.7	27.6
	Техникийн болон мэргэжлийн	6.2	12.0	58.9	75.3	28.7	21.1
	Тусгай мэргэжлийн дунд	6.6	15.3	49.7	76.9	29.8	28.2
	Дээд	8.9	21.8	42.6	81.3	37.6	35.6
Байршил	Нийслэл	10.7	17.6	32.5	81.5	37.2	49.9
	Аймгийн төв	7.3	16.0	53.1	82.2	35.0	37.2
	Сумын төв	5.2	19.2	66.8	69.7	30.9	0.1
	Хөдөө	7.6	19.3	76.0	65.1	35.0	1.5

Иргэд өөрийгөө болон эд хөрөнгөө хамгаалах зорилгоор гадуур явахдаа үнэтэй хувцас, эдлэл хэрэглэх, их хэмжээний бэлэн мөнгө биедээ авч явах, хэн нэгний хүчирхийлэлд өртөхөөс болгоомжилж задгай хувцаслахаас зайлсхийдэг байна. Нийт эмэгтэйчүүдийн 63.9 хувь нь задгай хувцаслаж гадуур явахаас зайлсхийдэг, 71.4 хувь нь их хэмжээний бэлэн мөнгө биедээ авч явахаас зайлсхийдэг гэж хариулсан нь эмэгтэйчүүд нийгмийн харилцаанд оролцоход илүү хүндрэл тулгардаг гэсэн дүр зургийг харуулна. Эсрэгээрээ эрэгтэйчүүдийн 56.5 хувь нь их хэмжээний бэлэн мөнгө биедээ авч явахаас зайлсхийдэг, 26.9 хувь нь үнэтэй хувцас, эдлэл хэрэглэж гадуур явахаас зайлсхийдэг гэж хариулсан нь эрэгтэйчүүд нийгмийн харилцаанд илүү айдас багатай хүндрэлгүй оролцох боломжтой байдаг гэсэн дүгнэлтэд хүргэж байна. Аливаа улс орон хүйсийн мэдрэмжтэй, айдасгүй, аюулгүй нийгмийг цогцлоох нь хүний эрх, шударга ёс, хүн төвтэй хөгжлийн талаарх асуудал юм.

Зураг 23.

Иргэдийн өдөр тутмын амьдралын хэв маяг, хүйсээр, хувиар



3.3

Гэмт хэрэгт хохирсон байдал

НҮБ-ын “Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирогчдын талаарх хууль цаазын үндсэн зарчмын тухай тунхаглал”-д гэмт хэргийн хохирогч гэж гэмт хэрэг, эрх мэдлээ хортойгоор ашигласан болон хүний эрх, хүмүүнлэгийн эрх зүйг зөрчсөн үйлдэл, эс үйлдлийн улмаас бие эрхтэн, оюун сэтгэхүйн хэвийн үйл ажиллагаа алдагдсан, сэтгэл санааны зовлон шаналалд автсан, эд материалын хохирол хүлээсэн, үндсэн эрх, эрх чөлөө нь ноцтой зөрчигдсөн хувь хүн болон хэсэг бүлэг хүмүүсийг хэлнэ гэж тодорхойлсон байна.

Энэ хэсэгт сүүлийн гурван жил болон нэг жилийн хугацаанд иргэдийн гэмт хэргийн улмаас хохирсон байдлын талаарх мэдээллийг гаргахыг зорилоо. Ингэхдээ 6 гэмт хэргийн төрлийг өрхөд чиглэсэн (тээврийн хэрэгсэл хулгайлах, тээврийн хэрэгслийн

эд анги хулгайлах, унадаг дугуй хөдөлгөөнт хэрэгсэл хулгайлах, орон байрны хулгай, мал хулгайлах, зам тээврийн осол) гэмт хэрэг, 10 гэмт хэргийн төрлийг хувь хүнд чиглэсэн (дээрэмдэх, хулгайлах, залилах, хахууль, хүчирхийлэл, заналхийлэх, цахим халдлага, ялгаварлан гадуурхалт, бэлгийн хүчирхийлэл, бэлгийн дарамт учруулах) гэмт хэрэг гэж ангилан авч үзсэн.

Нийт өрхийн 31.2 хувь сүүлийн 3 жилийн хугацаанд өрхөд чиглэсэн гэмт хэргийн хохирогч болж, үүнээс 14 ба түүнээс дээш насны хүн амын 24.6 хувь нь хувь хүнд чиглэсэн гэмт хэргийн хохирогч болсон байна (Хавсралт. Хүснэгт 3.1).

Судалгаанд сүүлийн 3 жилийн хугацаанд болон сүүлийн 12 сарын хугацаанд бүх төрлийн гэмт хэргийн хохирогч болсон тохиолдлыг болон давтамжийг асуусан ба хувь хүний асуулгад хариулсан иргэдийн хохирсон тохиолдол бүрийг асуусан. Харин хохирсон байдлын асуулгад олон удаагийн давтамжтай хохирсон гэж хариулсан иргэдийн зөвхөн сүүлийн 3 хохирлын тохиолдлыг лавлан асуусан. Хохирсон давтамжийн тоонд асуулгад хариулсан иргэдийн хохирсон бүх тохиолдол орсон болно.

Сүүлийн 3 жилийн хугацаанд бүх төрлийн гэмт хэргийн 15,232 тохиолдолд 10,361 хүн, сүүлийн 12 сарын хугацаанд бүх төрлийн гэмт хэргийн 6,821 тохиолдолд 4,663 хүн хохирсон байна.

Тээврийн хэрэгслийн хулгай (66.3 хувь), тээврийн хэрэгслийн эд ангийн хулгай (63.0 хувь), унадаг дугуй, хөдөлгөөнт хэрэгслийн хулгай (68.1 хувь)-н хохирогч иргэдийн дийлэнх нь эрэгтэйчүүд байгаа бол хүчирхийлэл (69.8 хувь), бэлгийн хүчирхийлэл (92.2 хувь), бэлгийн дарамт учруулах (95.8 хувь) гэмт хэргийн хохирогч болсон иргэдийн дийлэнх нь эмэгтэйчүүд байна (Хавсралт. Хүснэгт 3.2, 3.3, 3.4, 3.10, 3.16, 3.17).

Судалгааны үр дүнгээс Монгол Улсад үйлдэгддэг хамгийн түгээмэл гэмт хэргийг ялгаж харах боломжтой. Тодруулбал, судалгаанд хамрагдахаас өмнөх сүүлийн 3 жил болон сүүлийн 1 жилийн хугацаанд хамгийн их үйлдэгдсэн олон хүн хохирогч болсон хэргүүд хулгайлах, залилах, мал хулгайлах хэргүүд байна. Сүүлийн 3 жилийн байдлаар 14 ба түүнээс дээш насны арван хүн тутмын 1 нь хулгайлах (12.4 хувь), залилах (10.6 хувь) болон мал хулгайлах (8.0 хувь) гэмт хэргийн хохирогч болжээ. Сүүлийн 3 жил болон сүүлийн 1 жилийн гэмт хэргийн төрлийг харьцуулан харахад төдийлөн өөрчлөлт байхгүй бөгөөд хамгийн түгээмэл гардаг, иргэдийг хамгийн их хохироодог гэмт хэргийн төрөлд хулгайлах, залилах, мал хулгайлах, ялгаварлан гадуурхах, хүчирхийлэх хэргүүд орж байна. Хүний арьс өнгө, үндэс угсаа, шашин шүтлэг, хүйс, бэлгийн чиг баримжаа, нас, хөгжлийн бэрхшээл зэрэг ялгаатай байдлыг нь үндэслэн доромжлох, гадуурхах, эрх зөрчих,

эсвэл хүчирхийлэл үйлдэх явдал нь олон улсын болон дотоодын хууль эрх зүйн хүрээнд хүлээн зөвшөөрөгдөхгүй, нийгмийн ёс зүйд нийцэхгүй үйлдэлд ордог бөгөөд ялгаварлан гадуурхах гэмт хэрэгт тооцогддог. Ялгаварлан гадуурхах гэмт хэргийг Монгол Улсын Эрүүгийн хуулиар мөн гэмт хэрэгт тооцдог бөгөөд тухайн гэмт хэргийг үйлдсэн этгээдэд торгууль, хорих ял зэрэг шийтгэл оногдуулж байна.

Зураг 24.

Сүүлийн 3 жилийн хугацаанд хохирсон хүний тоо, гэмт хэргийн төрлөөр, хувиар



Зураг 25.

Сүүлийн 12 сарын хугацаанд гэмт хэрэгт хохисон хүний тоо, гэмт хэргийн төрлөөр, хувиар



Зураг 26.

Сүүлийн 3 жилд үйлдэгдсэн гэмт хэргийн тоо, тохиолдлын тоогоор, хувиар



Зураг 27.

Сүүлийн 12 сарын хугацаанд үйлдэгдсэн гэмт хэргийн тоо, тохиолдлын тоогоор, хувиар




Өмнөх хэсэгт бид гэмт хэрэгт хохирсон иргэдийн талаарх мэдээллийг хүргэсэн бол дараах хэсэгт сүүлийн 3 жил болон сүүлийн 12 сарын хугацаанд үйлдэгдсэн гэмт хэргийн талаарх мэдээллийг судалгааны дүнд үндэслэн танилцуулна. Үйлдэгдсэн гэмт хэргийн тоо, хохирсон хүний тооны мэдээлэл шууд уялдаатай бөгөөд хохирсон гэмт хэргийн төрөл болон үйлдэгдсэн гэмт хэргийн төрлийн ерөнхий хандлага ижил байгаа хэдий ч нэг

гэмт хэргийн хувьд нэлээн ялгаа харагдана. Тодруулбал, сүүлийн 3 жил болон сүүлийн 12 сарын хугацаанд үйлдэгдсэн гэмт хэргийн тоонд хүчирхийлэл үйлдсэн тохиолдлын тоо их байна. Сүүлийн 3 жилд хүчирхийллийн гэмт хэрэгт 968 иргэн хохирсон байхад хүчирхийллийн гэмт хэргийн тохиолдлын тоо 2260 буюу хохирогчийн тооноос 2.3 дахин их харин сүүлийн 12 сарын хугацаанд хүчирхийллийн гэмт хэрэгт 526 иргэн хохирсон байхад хүчирхийллийн гэмт хэргийн тохиолдлын тоо 1246 буюу 2.4 дахин их байгаа нь энэ төрлийн гэмт хэрэгт нэг хохирогч олон удаагийн давтамжтай өртөж байгааг илэрхийлэх үзүүлэлт байна.


Гэмт хэргийн хохирогч болох нь эмэгтэйчүүдэд илүү тохиолдож байна. Тодруулж харвал сүүлийн 3 жилийн хугацаанд хамгийн багадаа нэг гэмт хэргийн хохирогч болсон 14 ба түүнээс дээш насны нийт хүн амын 55.1 хувь нь эмэгтэй байгаа бол сүүлийн 12 сарын хугацаанд энэ хувь 55.8 байна өөрөөр хэлбэл гэмт хэргийн хохирогч болсон иргэдийн талаас илүү хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Яагаад эмэгтэйчүүд гэмт хэрэгт илүү өртөөд байна вэ? Энэ асуултад хариулах хэд хэдэн шалтгаанууд байж болох юм. Тухайлбал, нийгмийн хэвшмэл ойлголт буюу жендэрийн тэгш бус байдал тэднийг эмзэг байдалд оруулж гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн золиос болгож байх талтай. Мөн эдийн засгийн хараат байдал, хуулийн хэрэгжилт хангалтгүй, хохирогчийг хамгаалах тогтолцоо сул зэрэг нь хүчирхийллийг хүлцэх хандлагыг бий болгох суурь болж байх магадлалтай юм. Иймд эмэгтэйчүүдийн хүчирхийллээс өөрийгөө хамгаалах хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх, эрхээ хамгаалах боломжийг олгох нь чухал бөгөөд хүчирхийллийг тэвчихгүй нийгмийг бүрдүүлэх нь туйлын зорилго болно.

Зураг 28.

Сүүлийн 3 жилийн хугацаанд хамгийн багадаа нэг гэмт хэргийн хохирогч болсон байдал, хүйсээр, хувиар

**Зураг 29.**

Сүүлийн 12 сарын хугацаанд хамгийн багадаа нэг гэмт хэргийн хохирогч болсон байдал, хүйсээр, хувиар



Сүүлийн 12 сарын хугацаанд үйлдэгдсэн гэмт хэрэгт хохирсон хүн амын хувийг гэмт хэргийн төрлөөр болон байршил, бүсээр харвал ялгаа харагдана. Нийслэлд хулгайлах, залилах, ялгаварлан гадуурхах, зам тээврийн ослын, аймгийн төвд залилах, хүчирхийлэх, ялгаварлан гадуурхах, хулгайлах, сумын төвд мал хулгайлах, хүчирхийлэх, залилах, хөдөөд мал хулгайлах, ялгаварлан гадуурхах гэмт хэрэгт хохирогч илүү давамгайлж байна. Гэмт хэрэгт хохирсон байдал бүсийн хувьд ямар ялгаатай байгаа нь бас сонирхолтой бөгөөд Зүүн (12.4 хувь), Баруун (8.4 хувь), Хангайн (6.7 хувь) бүсийн хувьд мал хулгайлах гэмт хэрэгт хохирогч хамгийн их байна. Мал хулгайлах гэмт хэрэг нь хууль бусаар бусдын мал сүргийг хулгайлан авч, эд хөрөнгөд нь хохирол учруулах үйлдлийг хэлдэг бөгөөд Монгол Улсын Эрүүгийн хуульд онцгой анхаарал хандуулдаг хүнд гэмт хэрэгт тооцогдож байгаа хэдий ч хохирогчийн тоо ихтэй гэмт хэргийн нэг байсаар байна.

Хүснэгт 11.


Сүүлийн 12 сарын хугацаанд гэмт хэрэгт өртөж хохирсон 14 ба түүнээс дээш насны хүн амын хувь, бүс, байршлаар, гэмт хэргийн төрлөөр

	Байршил				Бүс					Улсын дундаж
	Нийслэл	Аймгийн төв	Сумын төв	Хөдөө	Нийслэл	Баруун	Хангайн	Төв	Зүүн	
Тээврийн хэрэгсэл хулгайлах	0.1	0.1	0.0	0.2	0.1	0.1	0.2	0.1	0.1	0.1
Тээврийн хэрэгслийн эд анги хулгайлах	2.6	1.3	0.7	0.9	2.6	1.0	0.8	1.0	2.1	1.8
Унадаг дугуй, хөдөлгөөнт хэрэгсэл хулгайлах	0.6	0.5	0.3	0.2	0.6	0.3	0.4	0.2	0.7	0.5
Орон байрны хулгай	2.5	1.8	2.1	1.8	2.5	2.0	2.0	1.1	2.7	2.2
Дээрэмдэх	0.4	0.2	-	0.1	0.4	0.1	0.1	0.2	0.0	0.3
Хулгайлах	7.2	3.4	1.8	1.6	7.2	2.3	2.9	1.5	3.2	4.7
Залилах	5.5	4.7	3.6	2.3	5.5	2.9	4.1	2.6	5.5	4.5
Хахууль	0.7	0.3	0.2	0.5	0.7	0.3	0.2	0.2	0.9	0.5
Хүчирхийлэл	3.0	4.0	3.7	2.9	3.0	3.3	3.0	2.6	7.2	3.3
Заналхийлэх	1.4	1.0	0.6	0.8	1.4	0.8	1.0	0.7	1.0	1.1
Мал хулгайлах	0.7	2.1	5.0	11.7	0.7	8.4	6.7	2.1	12.4	3.7
Цахим халдлага	2.2	2.5	1.7	0.9	2.2	0.9	2.2	1.5	2.6	2.0
Зам тээврийн осол	3.1	3.0	1.7	1.5	3.1	1.9	1.6	2.3	3.8	2.6
Ялгаварлан гадуурхалт	3.5	3.7	3.5	3.4	3.5	3.3	3.3	2.8	6.4	3.5
Бэлгийн хүчирхийлэл	0.1	0.1	0.2	0.1	0.1	0.2	0.1	0.0	0.2	0.1
Бэлгийн дарамт учруулах	0.4	0.4	0.5	0.1	0.4	0.3	0.2	0.2	0.8	0.3

Гэмт хэргийн хохирогч болсон ч эрх бүхий байгууллагад мэдэгдээгүй, мөн яагаад мэдэгдээгүй шалтгааны талаар энэ хэсэгт дэлгэрүүлж судлахыг зорьсон. Бодит амьдрал дээр хүмүүс ямар нэг гэмт хэргийн хохирогч болсноо эрх бүхий байгууллагад мэдэгдээгүй өнгөрөх тохиолдлууд их байдаг. Энэхүү судалгааны нэг гол зорилго нь нуугдмал гэмт хэргийн тоог илрүүлэх бөгөөд судалгааны асуулгад хохирогч болсон иргэдээс эрх бүхий байгууллагад мэдэгдсэн эсэх, мэдэгдээгүй бол яагаад мэдэгдээгүй шалтгааныг лавлан асуусан. Үр дүн бидэнд нуугдмал гэмт хэрэг буюу цагдаагийн байгууллагад мэдэгдээгүй, бүртгэгдээгүй гэмт хэрэг их байх магадлалтайг харуулж байна. Бүс, суурьшлаар харвал хоорондын ялгаа бараг байхгүй бөгөөд сүүлийн 3 жилд гэмт хэргийн хохирогч болсон арван хүн тутмын 2-3 нь эрх бүхий байгууллагад ханддаг 7-8 нь ханддаггүй байна. Гэмт хэргийг мэдээлэхгүй байх шалтгааныг судлах нь магадгүй хууль хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын үйл ажиллагаанд чухал мэдээлэл болох юм.

Зураг 30.

Сүүлийн 3 жилийн хугацаанд гэмт хэргийн талаар холбогдох эрх бүхий байгууллагад мэдэгдсэн эсэх, бүс, байршлаар, хувиар



Гэмт хэргийн төрлөөр нь авч үзвэл сүүлийн 3 жилийн хугацаанд гэмт хэргийн хохирогч болсон 14 ба түүнээс дээш насны хүн амын 72.3 хувь нь тээврийн хэрэгслийн хулгайг, 66.7 хувь нь зам тээврийн ослыг, 48.7 болон 47.0 хувь нь орон байрны хулгай, малын хулгайг эрх бүхий байгууллагад мэдээлсэн нь хамгийн өндөр байна. Харин хахуулийн гэмт хэргийн талаар 2.4 хувь мэдээлсэн гэжээ.

Хахуулийн гэмт хэргийн онцлог нь хохирлын хэмжээ шаардахгүй, үйлдэл төгссөн байхыг шаардахгүй (санал болгосон, амласан үйлдэл, эс үйлдэхүй) мөн өгсөн, авсан аль аль этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалттай тул ихэвчлэн 2 этгээдийн хооронд болон хэсэг бүлэг хаалттай хүрээнд үйлдэгддэг онцлогтой.

Эрүүгийн хуульд зааснаар “Хясан боогдуулсны улмаас” аргагүй байдалд орж хахууль өгч, нийтийн албан тушаалтны хуулийн дагуу албаны чиг үүргээ гүйцэтгэж үзүүлэх төрийн үйлчилгээг авсан хүн энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа илчлэн ирсэн бол түүний авсан төрийн үйлчилгээг хэвээр үлдээж ялаас чөлөөлнө гэж заасан бөгөөд эдгээрээс бусад ямар ч тохиолдолд хахууль өгсөн болон авсан этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалт үйлчилж байна.

Хахууль өгөх гэмт хэрэгт (хясан боогдуулснаас бусад тохиолдолд) хахууль өгсөн, авсан аль ч талыг хохирогч гэж үзэх боломжгүй бөгөөд гуравдагч тал буюу боломжоо хулгайлуулж буй иргэд, улс эх орон, нийтийн эрх ашиг зөрчигдөж, хохирогч болж байдаг онцлогтой. Авлигын гэмт хэрэг болон аливаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн хохирогч болохгүй байх нь тухайн хувь хүн, байгууллагын хандлагаас шалтгаалдаг. Тухайн хувь хүн, эсхүл байгууллагын нийгэм, эдийн засгийн ашиг сонирхлоос үүдэлтэйгээр энэ төрлийн гэмт хэрэг үйлдэх, өртөх, оролцогч болох талтай.

Зураг 31-ээс харахад хахуулийн гэмт хэргийн талаар эрх бүхий байгууллагад мэдэгдсэн тохиолдол хамгийн цөөн байгаа нь хахууль өгөх, авах гэмт хэргийн хор хөнөөл, хор уршгийн талаар иргэд тэр бүр мэдлэг, мэдээлэлгүй, өгсөн, авсан аль аль талд хуулийн хариуцлага хүлээлгэдэг зохицуулалттайгаас гадна хөндлөнгөөс энэ талаар мэдсэн этгээд мэдээлэхгүй байгаа нь шүгэл үлээгчийг хамгаалах эрх зүйн орчин манай улсад бүрдээгүй зэрэг хэд хэдэн шалтгаан, хүчин зүйлийн улмаас эрх бүхий байгууллагад энэ төрлийн гэмт хэргийг мэдээлэх байдал хангалтгүй байж болохоор байна.

Зураг 31.

Сүүлийн 3 жилийн хугацаанд гэмт хэргийн талаар эрх бүхий байгууллагад мэдэгдсэн байдал, гэмт хэргийн төрлөөр, хувиар




Иргэд гэмт хэргийн хохирогч болсон боловч эрх бүхий байгууллагад мэдэгдээгүй шалтгааныг судлах нь чухал юм. Бодит байдалд гэмт хэргийг мэдээлэхгүй, нуун дарагдуулах хэд хэдэн шалтгаан байх боломжтой. Үүнд, нэгдүгээрт, дарамтад орох айдас болон учрах эрсдэлээс шалтгаалан хохирогч эсвэл гэрч дуугүй байх. Хоёрдугаарт, гэмт этгээдтэй холбоотой эсвэл ойр дотны хүн байвал мэдээлэхгүй байх. Гуравдугаарт, хууль хяналтын байгууллагад итгэхгүй байх, шийдвэр гаргалт удаашралтай, хүндрэл, чирэгдэл учруулдаг зэрэг үндсэн шалтгаанууд байх боломжтой.

Судалгааны үр дүнгээр хүчирхийлэх болон мал хулгайлах гэмт хэргийн хохирогчийн талаас илүү нь асуудлыг өөрсдөө шийдвэрлэсэн байна. Өөрөөр хэлбэл, малын хулгайчийг өөрөө олсон байна. Харин хүчирхийллийн гэмт хэргийн хохирогчийн өөрөө шийдвэрлэсэн гэдэг хариултыг илүү дэлгэрүүлж судлах шаардлагатай бөгөөд хүчирхийллийн гэмт хэргийг хэрхэн өөрөө шийдвэрлэж болох нь тодорхойгүй хэвээр үлдлээ. Харин иргэд хулгайлах болон залилах гэмт хэргийн тухайд хангалттай нотлох баримт байхгүйгээс шалтгаалан эрх бүхий байгууллагад мэдэгдэхгүй өнгөрдөг байна. Нэг анхаармаар тоо баримт нь хулгайлах болон залилах гэмт хэргийн хохирогчид эрх бүхий байгууллага хангалттай арга хэмжээ авахгүй гэж үзсэн учраас мэдээлээгүй гэсэн хувь өндөр байна.

Зураг 32.


Сүүлийн 3 жилийн хугацаанд гэмт хэргийн талаар эрх бүхий байгууллагад мэдэгдээгүй шалтгаан, сонгосон гэмт хэргийн төрлөөр, хувиар



Иргэд гэмт хэрэг болсон талаарх мэдээллийг хамгийн түрүүнд цагдаагийн байгууллагад мэдэгддэг. Цагдаагийн байгууллага нь тус мэдээллийн дагуу тодорхой арга хэмжээ авсан эсэхийг судалгааны асуулгад тусгасан ба гэмт хэргийн талаар цагдаагийн байгууллагад мэдэгдсэн гэж хариулсан иргэдийн 52.3 хувь нь цагдаагийн байгууллага мэдээллийн дагуу тодорхой арга хэмжээ авсан гэж хариулсан байна. Эсрэгээрээ иргэдийн цагдаад мэдэгдсэн гэмт хэргийн 44.3 хувьд нь ямар нэгэн арга хэмжээ аваагүй эсвэл авсан ч иргэдэд эргэж мэдэгдээгүй байна. Өөрөөр хэлбэл иргэд мэдээлсэн гэмт хэрэг нь хэрхэн шийдэгдсэн талаар ямар нэг хариу аваагүй нь магадгүй нуугдмал гэмт хэрэг өсөх эрх бүхий байгууллагад мэдээлэл өгөхгүй байхад нөлөө үзүүлж байж болох юм.

Зураг 33.


Сүүлийн 3 жилийн хугацаанд цагдаагийн байгууллага мэдээллийн дагуу арга хэмжээ авсан байдал, хувиар



Иргэдээс хууль сахиулах, шүүхийн эрх бүхий байгууллагуудын гэмт хэргийн мэдээллийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээнд хэр сэтгэл ханамжтай байдаг талаар асуухад шүүхийн байгууллагад арван хүн тутмын 6 нь сэтгэл ханамжтай байдгаа илэрхийлжээ. Харин цагдаагийн байгууллагын гэмт хэргийн мэдээллийн дагуу авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд арван хүн тутмын 6 нь сэтгэл ханамжгүй байв.

Зураг 34.

Сүүлийн 3 жилийн хугацаанд иргэдийн эрх бүхий байгууллагуудын гэмт хэргийн мэдээлэлд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны сэтгэл ханамж, эрх бүхий байгууллагаар, дүнд эзлэх хувиар



Энэ удаагийн судалгаагаар бид гэмт хэрэг гаралтад улирлын нөлөө байгаа эсэхийг тодруулах зорилгоор тухайн гэмт хэрэг аль улиралд үйлдэгдсэн талаар мэдээлэл цуглуулсан. Монгол Улс жилийн дөрвөн улиралтай эрс тэс уур амьсгалтай орон бөгөөд энэ онцлог нь гэмт хэргийн гаралтад нөлөө үзүүлдэг эсэхийг судаллаа. Гэмт хэргийн зарим төрлүүдэд гэмт хэрэг гарсан хугацааг улирлаар харахад унадаг дугуй, хөдөлгөөнт хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, түүний эд ангитай холбоотой хулгай, бэлгийн хүчирхийлэл, орон байрны хулгайн гэмт хэрэг зуны улиралд илүү үйлдэгддэг, хахууль, ялгаварлан гадуурхалт, зам тээврийн осол, цахим халдлага, малын хулгайн хэрэг намрын улиралд илүү үйлдэгдсэн байв. Өвлийн улиралд гэмт хэргийн гаралт харьцангуй багасах хандлагатай байгаа нь хүйтэн сэрүүний улмаас хүмүүсийн хөдөлгөөн хязгаарлагдаж, нийгмийн үйл ажиллагаа багасдагтай холбоотой байж болох юм.

Хүснэгт 12.

Сүүлийн 12 сард үйлдэгдсэн гэмт хэрэг, улирлаар, хувиар

Гэмт хэргийн гаралт	Хаврын улирал	Зуны улирал	Намрын улирал	Өвлийн улирал
Тээврийн хэрэгсэл хулгайлах	19.2	50.7	21.9	8.2
Тээврийн хэрэгслийн эд анги хулгайлах	25.2	30.1	20.9	23.8
Унадаг дугуй, хөдөлгөөнт хэрэгслийн хулгай	11.9	53.7	27.4	7.0

Гэмт хэргийн гаралт	Хаврын улирал	Зуны улирал	Намрын улирал	Өвлийн улирал
Орон байрны хулгай	21.6	35.1	27.8	15.5
Дээрэмдэх	20.0	28.0	24.0	28.0
Хулгайлах	19.5	31.4	28.7	20.4
Залилах	26.3	29.4	25.1	19.2
Хахууль	23.7	26.0	40.2	10.1
Заналхийлэх	23.0	28.4	29.7	18.9
Мал хулгайлах	17.7	25.3	29.9	27.1
Цахим халдлага	18.9	26.1	30.2	24.8
Зам тээврийн осол	19.4	31.2	33.8	15.6
Ялгаварлан гадуурхалт	17.5	28.0	37.7	16.8
Бэлгийн хүчирхийлэл	23.0	38.2	22.9	15.9

Мөн тухайн хэрэг үйлдэгдсэн цаг хугацааг өглөө, өдөр, үдэш, шөнө гэсэн байдлаар цуглуулав. Судалгааны үр дүнгээр тээврийн хэрэгсэл болон түүний эд ангийн хулгайг шөнийн цагаар, унадаг дугуй, хөдөлгөөнт хэрэгслийн хулгайг өдрийн цагаар, орон байрны хулгайг өдөр болон шөнийн цагаар, халаасны хулгайг өдрийн цагаар хамгийн ихээр үйлддэг байна. Хулгайлах гэмт хэрэг өдрийн цагаар их болж байгаа нь гудамж, талбай, үйлчилгээний газруудад хөл хөдөлгөөн их байдагтай холбоотой байж болох юм. Харин иргэд өдрийн цагаар гэрээ эзэнгүй орхиж ажил, сургуульдаа явдагтай холбоотой орон байрны хулгай өдрийн цагаар их үйлдэгддэг байна.

Хүснэгт 13.

Сүүлийн 12 сард үйлдэгдсэн гэмт хэрэг, хугацаагаар, хувиар

Гэмт хэргийн гаралт	Өглөө	Өдөр	Үдэш	Шөнө
Тээврийн хэрэгслийн хулгай	1.4	20.5	23.3	54.8
Тээврийн хэрэгслийн эд ангийн хулгай	3.6	18.6	12.2	65.6
Унадаг дугуй, хөдөлгөөнт хэрэгслийн хулгай	7.5	52.7	13.4	26.4
Орон байрны хулгай	4.3	39.9	17.0	38.8
Дээрэмдэх	6.4	39.2	27.2	27.2
Хулгайлах	10.2	63.0	21.3	5.5

Дээр дурдсанчлан хүчирхийллийн гэмт хэрэг Монгол Улсад түгээмэл, ялангуяа давтамж өндөртэй гардаг гэмт хэргийн нэг гэдгийг тоо баримт харуулсан. Хүчирхийллийн гэмт хэрэг, тэр дундаа гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг нуугдмал явагддаг гэмт хэргийн тоонд ордог. Гэр бүлийн хүчирхийлэл гэдэг нь гэр бүлийн гишүүдийн хоорондын харилцаанд илэрдэг, бие махбодын, сэтгэл санааны, бэлгийн, эдийн засгийн болон бусад хэлбэрийн дарамт, хүчирхийлэл үйлдэх үйлдэл бөгөөд энэ нь хүний эрхийн

ноцтой зөрчил учраас хохирогчид болон нийгэмд олон сөрөг үр дагавар авчирдаг.

Судалгааны үр дүнгээр хүчирхийлэл болон заналхийллийг хохирогчийн эхнэр/нөхөр, хамтран амьдрагч нь хамгийн ихээр үйлддэг гэжээ. Эхнэр/нөхөр, хамтран амьдрагч үйлдэж буй энэ гэмт хэрэг нь гэр бүлийн хүчирхийллийн хамгийн тод илрэл бөгөөд энэ гэмт хэргийн хохирогч нь ихэвчлэн эмэгтэйчүүд, хүүхдүүд, өндөр настангууд байдаг. Энэ гэмт хэргийн нэг аюул нь ихэнхдээ гэр бүлийн хүрээнд нууцлагддаг тул хуулийн байгууллагад мэдэгдэхгүй, илрэхгүй өнгөрөх нь элбэг. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд хүчирхийлэл үйлдэгчид оногдуулах хариуцлага болон хохирогчийг хамгаалах эрх зүйн зохицуулалт байдаг хэдий ч бодит амьдралд хэрэгжилт нь хэрхэн хангагдаж байгааг анхаарах шаардлагатай юм.

Харин ялгаварлан гадуурхалтыг найз нөхөд болон хамтран ажиллагч илүү гаргаж байгаа нь анхаарахгүй өнгөрч болохгүй гэмт хэргийн нэг төрөл юм. Энэ төрлийн гэмт хэргийг бууруулах нэг оновчтой арга нь хүний эрх, тэгш эрхийн талаар нийгмийн боловсролыг дээшлүүлэх, ялгаварлан гадуурхалтын хор уршгийн талаар мэдлэг мэдээлэл олгох юм.

Зураг 35.

Хохирогч болон гэмт этгээдийн хамаарал, гэмт хэргийн төрлөөр, хувиар



Согтуу эсвэл мансуурсан үедээ гэмт хэрэг үйлдэх нь гэмт хэргийн өдөөгч гол хүчин зүйлсийн нэг байдаг бөгөөд өөрөөр хэлбэл ийм үедээ хүн бодит байдалд дүгнэлт хийх, ухамсарлах чадвар буурсан байдаг. Согтууруулах ундаа, мансууруулах бодисын нөлөөнд автсан үед хүмүүсийн шийдвэр гаргах чадвар сулрах нь гэмт хэрэг үйлдэх магадлалыг нэмэгдүүлдэг байна. Монгол Улсын Эрүүгийн хуульд согтууруулах ундаа болон мансууруулах бодисын нөлөөнд гэмт хэрэг үйлдсэн бол илүү чангатгасан ял шийтгэл ногдуулах

зохицуулалт байдаг. Гэсэн хэдий ч энэ төрлийн гэмт хэргийн гаралт буурахгүй нийгэмд асуудал болсон хэвээр байна. Ихэвчлэн зодоон, хүчирхийлэл, зам тээврийн ослын хэргүүд согтуу, мансуурсан байх үед илүү давамгай үйлдэгдэж байна.

Судалгаагаар бид тухайн гэмт хэрэг үйлдэгдэх үед гэмт хэрэгтэн болон хохирогчийг согтуу эсвэл мансуурсан байсан эсэхийг асууж тодруулсан. Хүчирхийлэх (31.7 хувь) болон заналхийлэх (36.8 хувь) гэмт хэргийг арван гэмт хэрэгтэн тутмын 3 нь согтуу болон мансуурсан байхдаа үйлддэг байна.

Хүснэгт 14.

Согтуу, мансуурсан үедээ гэмт хэрэг үйлдсэн болон хохирсон байдал, хувиар

Гэмт хэргийн төрөл	Гэмт этгээд	Хохирогч
Хүчирхийлэх	31.7	6.9
Заналхийлэх	36.8	4.6
Зам тээврийн осол	15.1	9.1

Судалгаагаар зарим гэмт хэргийн төрлүүдийн хувьд гэмт хэрэг болсон байршилд хяналтын камертай байсан эсэхийг асуусан ба дийлэнх хувь нь хяналтын камер байгаагүй гэж хариулжээ. Тухайлбал, хулгайн гэмт хэрэгт хохирсон нийслэлийн иргэдийн 14.8 хувь нь хулгай болсон байршилд хяналтын камер байсан, 73.3 хувь нь камер байгаагүй гэж гэж хариулсан бол үлдсэн хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Дүгнэхэд гэмт этгээдүүд хэрэг үйлдэхдээ хяналтын камергүй газрыг илүү сонгож үйлддэг байх боломжтой.

Хүснэгт 15.

Гэмт хэрэг үйлдэгдсэн байршилд хяналтын камер байсан хувь, сүүлийн 3 жилээр

Гэмт хэргийн төрөл	Нийслэл	Аймгийн төв	Сумын төв	Хөдөө
Тээврийн хэрэгсэл хулгайлах	19.6	28.8	7.0	4.3
Тээврийн хэрэгслийн эд анги хулгайлах	28.1	16.7	7.0	5.6
Унадаг дугуй, хөдөлгөөнт хэрэгсэл хулгайлах	28.8	9.4	17.3	4.1
Дээрэмдэх	16.1	12.2	16.2	9.2
Хулгайлах	14.8	16.7	14.7	19.7

Хүчирхийлэх заналхийлэх, бэлгийн хүчирхийлэл үйлдэхдээ гэмт этгээд айлгаж сүрдүүлэх болон гэмтээх зорилгоор зэвсгийн шинжтэй зүйл ашигласан эсэх талаарх мэдээллийг судалгаагаар цуглуулсан. Гэмт хэрэг үйлдэхдээ зэвсгийн шинжтэй зүйл ашиглах нь олон улсад хууль зүйн талаасаа ноцтой гэмт хэрэгт тооцогддог. Зэвсгийн шинжтэй зүйл гэдэгт жинхэнэ зэвсгээс гадна ямар нэгэн байдлаар хүний амь нас, эрүүл мэндэд хор уршиг учруулж болох зүйлсийг хэлдэг. Жишээ нь, хутга, сэрээ, гар утас, хүчтэй лазер гэрэл, төмөр саваа, цавуу, мод, чулуу гэх мэт. Судалгааны үр дүнгээр гэмт этгээд заналхийлэх гэмт хэргийг үйлдэхдээ зэвсгийн шинжтэй зүйл хэрэглэсэн нь 7.5 хувь, хүчирхийллийн гэмт хэрэгт 7.3 хувь, бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгт 1.6 хувь байна. Гэмт хэрэг үйлдэхдээ зэвсгийн шинжтэй зүйл ашигласан үед оногдуулах ялын хэмжээг тухайн улсын хууль тогтоомжоор тодорхойлдог бөгөөд дийлэнх улс оронд ийм гэмт хэргийг хүндрүүлж, хатуу шийтгэл оногдуулдаг байна. Түүнчлэн зэвсгийн шинжтэй зүйл ашигласан нь гэмт хэргийн үйлдлийг илүү аюултай болгодог тул энэ төрлийн гэмт хэрэгт илүү хүнд ялын хариуцлага тооцох нь бий.

Хүснэгт 16.

Гэмт хэрэгт өртөх үед гэмт этгээд зэвсгийн шинжтэй зүйл хэрэглэсэн эсвэл хэрэглэхээр заналхийлсэн байдал, хувиар

Гэмт хэргийн төрөл	Тийм	Үгүй	Мэдэхгүй/Хариулаагүй
Хүчирхийлэл	7.3	89.4	3.3
Заналхийлэх	7.5	89.4	3.1
Бэлгийн хүчирхийлэл	1.6	94.7	3.7

Энэ хэсэгт бид гэмт этгээд тухайн гэмт хэргийг үйлдэхдээ ашигласан зэвсгийн шинжтэй зүйлсийг төрлөөр нь харуулав. Гэмт этгээд хүчирхийлэх, заналхийлэхдээ хутга, хурц үзүүртэй зүйл илүү ашигладаг бол бэлгийн хүчирхийлэл үйлдэхдээ хутга, хурц үзүүртэй зүйл ашиглахаас гадна цохиур, труба, олс гэх мэт зүйлсийг мөн ашигласан байна.

Хүснэгт 17.

Гэмт хэрэг үйлдэх үед гэмт этгээдийн хэрэглэсэн зэвсгийн шинжтэй зүйл, хувиар

Гэмт хэргийн төрөл	Галт зэвсэг	Хутга, хурц үзүүртэй зүйл	Цохиур, труба, олс, нум сум, гардан тулааны хэрэгсэл гэх мэт	Бусад (тэсэрч дэлбэрэх бодис, гал, утаа, буцалсан ус, тос, газ, уур бүхий боллон халуун зүйл гэх мэт)
Хүчирхийлэл	4.3	67.4	32.1	6.7
Заналхийлэх	-	57.1	35.8	6.6
Бэлгийн хүчирхийлэл	-	62.7	54.1	-

3.3.1-3.3.4 хэсгүүдэд сүүлийн 12 сарын хугацаанд үйлдэгдсэн гэмт хэргийн тохиолдлын тоо хамгийн их 4 гэмт хэрэг (хулгайлах, мал хулгайлах, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт)-ийн төрлийн мэдээллийг дэлгэрэнгүй авч үзнэ. Бусад гэмт хэргийн төрлийн мэдээллийг хавсралт хэсгээс харах боломжтой.

3.3.1

Хулгайлах гэмт хэрэгт хохирсон байдал

Хулгайлах гэмт хэрэг гэдэг нь бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсан үйлдлийг хэлнэ. Энэ төрлийн гэмт хэрэг нь олон улсад тухайн хүний өмчийн эрхийг зөрчиж, түүний эд хөрөнгө, эрх ашгийг хохироох явдал гэж үзэгддэг бөгөөд эрүүгийн хуулиар зохицуулагддаг. Хулгайн гэмт хэргийн маш олон төрөл тохиолдлууд байж болох ба манай улсад хамгийн түгээмэл тохиолддог нь орон байрны, дэлгүүр, худалдааны төвийн болон халаасны хулгай байдаг.

Хулгайн гэмт хэргийн тохиолдол нийслэл хотод хамгийн өндөр байдаг ба эмэгтэйчүүд эрэгтэйчүүдтэй харьцуулвал хохирогч болсон байдал их. Мөн 14-19 насны хүүхдүүд бусад насныхантай харьцуулвал хулгайн гэмт хэргийн хохирогч болох нь их байна. Сууцны хувьд орон сууцны байшин болон сууцны тусдаа байшингийн хулгайн тохиолдол бусад сууцтай харьцуулахад мөн өндөр байна.

Хүснэгт 18.

Сүүлийн 3 жилд болон сүүлийн 12 сарын хугацаанд хулгайлах гэмт хэрэгт хохирсон байдал, сонгосон үзүүлэлт, дүнд эзлэх хувиар

Үзүүлэлт		Хулгайлах гэмт хэргийн хохирогч болсон байдал	
		Сүүлийн 3 жилд	Сүүлийн 12 сард
Хүйс	Эрэгтэй	40.1	42.5
	Эмэгтэй	59.9	57.5
Насны бүлэг	14-19	20.5	29.8
	20-24	10.0	11.2
	25-29	10.9	9.0
	30-34	11.9	12.2
	35-39	10.5	8.6
	40-44	7.9	5.5
	45-49	8.4	6.3
	50-54	6.7	4.8
	55-59	4.9	6.2
	60+	8.2	6.4

Үзүүлэлт		Хулгайлах гэмт хэргийн хохирогч болсон байдал	
		Сүүлийн 3 жилд	Сүүлийн 12 сард
Үйлдлийн чадвар	Хүндрэлтэй	6.8	5.9
	хүндрэлгүй	93.2	94.1
Байршил	Нийслэл	72.2	72.8
	Аймгийн төв	14.7	16.2
	Сумын төв	4.9	3.8
	Хөдөө	8.1	7.3
Бүс	Баруун бүс	6.2	6.1
	Хангайн бүс	10.1	11.4
	Төвийн бүс	8.2	5.
	Зүүн бүс	3.2	4.6
	Нийслэл	72.2	72.8
	Гэр	22.9	22.8
Сууцны төрөл	Орон сууцны байшин	36.0	38.1
	Бие даасан тохилог сууц	0.1	
	Сууцны тусдаа байшин	39.3	37.9
	Нийтийн байр (ажилчдын, оюутны, бусад)	1.5	0.9
	Зориулалтын бус сууц	0.3	0.3

Сүүлийн 12 сарын хугацаанд хулгайлах гэмт хэргийн хохирогч болсон иргэдийн 71.9 хувь нь гар утсаа хулгайд алдсан байна. Гар утасны хулгай нь хамгийн түгээмэл бөгөөд хялбар хийх боломжтой гэмт хэргийн төрөл юм. Гар утасны хулгай нь тухайн иргэний зөвхөн эд хөрөнгийг хулгайлах төдийгүй, хохирогчийн хувийн мэдээлэл, санхүүгийн мэдээлэл зэрэг чухал мэдээллийг алдах эрсдэлийг үүсгэдэг. Монгол Улсад гар утасны хулгай сүүлийн жилүүдэд ихсэж байгаа гэмт хэргийн нэг бөгөөд энэ төрлийн хулгай нь ихэвчлэн олон нийтийн газарт, гудамжинд, нийтийн тээвэрт эсвэл олон хүнтэй газруудад элбэг тохиолддог. Өнөөдөр гар утас нь хүний хувийн мэдээллийг хадгалах, олон төрлийн үйлчилгээнд холбогдох хэрэгсэл болсон бөгөөд байгууллага, хувь хүний хувийн мэдээлэл алдагдах эрсдэлийг бий болгохоос гадна банкны дансанд байгаа мөнгөө алдах зэрэг давхар олон эрсдэлийг дагуулсаар байна. Товчоор хэлбэл, гар утасны хулгай нь зөвхөн эд хөрөнгө хулгайлах хэрэг төдийгүй хувь хүний мэдээлэл, аюулгүй байдлыг эрсдэлд оруулж буй гэмт хэрэг юм.

Зураг 36.


Хамгийн их хулгайлагдсан эд зүйлс, сүүлийн 12 сарын байдлаар, хувиар



Нийслэлийн иргэдийн 80.1 хувь нь амьдарч байгаа газартаа буюу нийслэл хотод хулгайн хохирогч болсон гэж хариулсан бол сумын төв, хөдөөгийн иргэдийн дийлэнх нь өөр хот, аймаг, сум, хөдөөд эд зүйлээ хулгайд алдсан гэсэн байна. Хулгайн гэмт хэргийн ихэнх тохиолдол нийслэл хотод үйлдэгдэж байна гэж дүгнэж болохоор байна.


Зураг 37.

Хулгайлах гэмт хэрэг үйлдэгдсэн газар, сүүлийн 12 сарын байдлаар, байршлаар, дүнд эзлэх хувиар



Зураг 38.

Хулгайлах гэмт хэрэг болсон байршил, сүүлийн 12 сарын байдлаар, дүнд эзлэх хувиар




Хулгайлах гэмт хэрэг болсон байршлыг авч үзвэл нийтийн тээвэрт хамгийн их хулгайн гэмт хэрэг болдог буюу 22.5 хувь байна. Ялангуяа нийслэл хотод нийтийн тээвэр болон олон нийтийн газарт энэ гэмт хэрэг үйлдэгдэх нь элбэг хандлагатай.

Хулгайлах гэмт хэргийн хохирогч болсон иргэдийн 76.6 хувь нь эрх бүхий байгууллагад мэдэгдээгүй байна. Хулгайн хэргийг эрх бүхий байгууллагад мэдэгдэхгүй байх хэд хэдэн шалтгаан байж магадгүй. Эдгээр шалтгаанууд нь хохирогчийн хувийн сэтгэл зүй, хуулийн мэдлэг, нийгмийн орчин эсвэл гэмт хэргийн нөхцөл байдалтай холбоотой. Тухайлбал, айж эмээх буюу айдас – хулгай нь зэвсэгтэй, хүч хэрэглэсэн, дарамталсан, аюулгүй байдалд нь заналхийлсэн тохиолдолд мэдэгдэхгүй байж болно. Мөн нийгмийн харилцаанд нь зөрчилдөөн, асуудал үүсэхээс айх өөрөөр хэлбэл хохирогч нь гэмт хэрэг гарсан орчин дахь хүн хоорондын маргаан, хардалт үүсэхээс айх юм. Зарим тохиолдолд гэмт хэрэг үйлдэгчтэй танил эсвэл ямар нэг байдлаар холбоотой байдаг нь тухайн гэмт хэргийг мэдэгдэхгүй өнгөрөх нэг нөхцөл болно. Мөн хохирогч нь хулгайн хэргийг хэрхэн мэдэгдэх талаар болон ямар байгууллагад хандах, хэрхэн гомдол гаргах талаар ойлголтгүй байж болно. Зарим тохиолдолд хохирогч нь хулгайлагдсан эд зүйлсийн үнэ цэнийг бага гэж үзэх, мөн хулгайлсан этгээдийн шийтгэл бага гэж үзэн эрх бүхий байгууллагад мэдээлэхгүй өнгөрөх, мөн мэдэгдэхгүй байвал илүү хялбар буюу олон асуудал үүсэхгүй, цаг хугацаа, мөнгө хөрөнгө зарцуулахгүй зэрэг давуу талтай гэж үзэн мэдэгдэхгүй байж болно.

Зураг 39.


Хулгайлах гэмт хэргийн талаар эрх бүхий байгууллагад мэдэгдсэн байдал, сүүлийн 12 сарын байдлаар, хувиар



Иргэдийн хулгайлах гэмт хэргийн талаар мэдэгдээгүй шалтгааны дийлэнх нь хангалттай нотлох баримт байхгүй гэж үзсэнийх байна. Мөн дөрвөн иргэн тутмын 1 нь эрх бүхий байгууллага хангалттай арга хэмжээ авахгүй гэж үзжээ. Иргэдийн хулгайн хэргийг мэдэгдэж хууль сахиулах байгууллагад хэрхэн хандах талаарх мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх, гэмт этгээдэд хүлээлгэх хуулийн хариуцлагыг ойлгуулах нь чухал бөгөөд хулгайн хэргийг багасгахын тулд хяналттай, камертай, гэрэлтүүлэгтэй орчинг нэмэгдүүлэх нь бас гол арга хэмжээ болно.

Зураг 40.

Хулгайлах гэмт хэргийн талаар эрх бүхий байгууллагад мэдэгдээгүй шалтгаан, сүүлийн 12 сарын байдлаар, хувиар



3.3.2

Мал хулгайлах гэмт хэрэгт хохирсон байдал

Мал хулгайлах гэмт хэрэг нь хохирогчийн мал, амьтдыг зөвшөөрөлгүйгээр хулгайлах үйлдлийг хэлнэ. Хулгай нь зохион байгуулалттай, олон хүний оролцоотой байж болно. Судалгаанд малын хулгайн гэмт хэрэгт хонь, ямаа, адуу, үхэр тэмээн хулгайг хамааруулан тодорхойлсон.

Монгол Улсын Эрүүгийн хуульд мал хулгайлах гэмт хэрэг нь хүнд гэмт хэрэгт тооцогддог бөгөөд завшсан малыг буцаан өгөх, төлбөр төлүүлэх, эсвэл шийтгэл оноох зэрэг хуулийн хариуцлага хүлээлгэдэг. Малын хулгай нь малчдын амьжиргаанд шууд сөргөөр нөлөө үзүүлэхүйц, нийгмийн аюулгүй байдалд эрсдэл учруулж болох хүнд гэмт хэрэг гэж үзэн ял шийтгэл өндөр оногдуулдаг байна.

Малын хулгайг тодорхой хэдэн төрөлд хувааж болох бөгөөд их хэмжээний мал хулгайлах буюу нийт малын хулгай өөрөөр хэлбэл олон төрлийн олон тооны мал хулгайлах, малын тодорхой хэсгийг буюу тухайлбал, хурдны морь, саалийн үнээ гэх мэт үнэ цэнэ хүрэх малын хулгай, бага хэмжээтэй малын хулгай буюу нэг мал хулгайлах тохиолдол зэргийг хамруулж ойлгоно. Манай улсад хамгийн түгээмэл тохиолддог малын хулгайд нэг мал хулгайлах ордог бөгөөд малыг бэлчээрийн ойр орчмоос хулгайлах үйлдэл нийтлэг байна.

Малын хулгайн гэмт хэргийг байршил болон бүсийн хувьд ямар дүр зурагтай байгааг судалгааны үр дүнгээс харвал, мэдээж хөдөөгийн суурьшилд их үйлдэгддэг, Хангайн бүсэд бусад бүстэй харьцуулахад хохирогч ихтэй гэмт үйлдэл өндөр байна. Төвийн бүсэд сүүлийн гурван жилийн хугацаанд өндөр байсан ч сүүлийн нэг жилд их буурсан, харин Баруун болон Зүүн бүсийн хохирогчийн хувь нэмэгдсэн хандлагатай байна.

Хүснэгт 19.

Сүүлийн 3 жилд болон сүүлийн 12 сарын хугацаанд мал хулгайлах гэмт хэрэгт өртөж хохирсон хохирогчийн байдал, бүс, байршлаар, дүнд эзлэх хувиар


Үзүүлэлт		Мал хулгайлах гэмт хэрэгт хохирсон байдал	
		Сүүлийн 3 жилд	Сүүлийн 12 сард
Байршил	Нийслэл	8.2	8.8
	Аймгийн төв	17.2	13.1
	Сумын төв	14.6	12.8
	Хөдөө	59.9	65.4
Бүс	Баруун бүс	20.2	26.1
	Хангайн бүс	31.4	31.6
	Төвийн бүс	29.0	9.1
	Зүүн бүс	11.2	24.4
	Нийслэл	8.2	8.8

Малаа хулгайд алдсан өрхийн 95.1 хувь нь бэлчээрээс, 3.4 хувь нь хотноосоо малаа алдсан гэж хариулсан байна. Сүүлийн 12 сарын хугацаанд адуу, үхэр хамгийн их хулгайд алдагдсан байна.

Баруун бүсэд тэмээг хамгийн их (58.5 хувь) хулгайд алддаг бол Хангайн бүсэд таван хошуу малын бүх төрлийн хулгай өндөр байна. Харин Зүүн бүсэд үхрийн хулгайн гэмт хэрэг бусад малын хулгайгаасаа их байна.


Зураг 41.

Сүүлийн 12 сарын хугацаанд малаа хулгайд алдсан өрх, малын төрөл, хувиар



Зураг 42.


Сүүлийн 12 сарын хугацаанд малаа хулгайд алдсан өрх, бүс, байршлаар, хувиар



Сүүлийн 12 сарын хугацаанд бод малаа хулгайд алдсан өрхийн тоо 762 буюу бог малаа алдсан өрхөөс 3 дахин их байгаа бол малын тоогоороо бог мал 4220 ширхэг буюу бод малаас 2 дахин их хулгайд алдсан байна.

Зураг 43.

Сүүлийн 12 сарын хугацаанд малаа хулгайд алдсан өрхийн тоо, малын тоогоор



3.3.3

Хүчирхийллийн улмаас хохирсон байдал

Хүчирхийлэл гэдэг нь бусдын бие махбодид шууд болон шууд бус байдлаар хүч хэрэглэн гэмтэл учруулах, эсвэл хүний сэтгэл санааг гэмтээх, айлгах зорилгоор үйлдэгддэг гэмт хэргийн нэг төрөл бөгөөд хамгийн нийтлэг үйлдэгддэг гэмт хэрэгт ордог. Энэ төрлийн гэмт хэрэг нь олон төрлийн үйлдэлтэй байж болно. Тухайлбал, бие махбодын, сэтгэл санааны, бэлгийн гэх зэрэг. Бие махбодын хүчирхийлэлд тамлан зовоох буюу алгадах, цохих, зодох, амь насанд нь аюул учруулах гэх мэт бүх хэлбэрийн биеийн хүчирхийлэл орно. Сэтгэл санааны хүчирхийлэлд сэтгэл санааны дарамт үүсгэх айлгах, сүрдүүлэх, доромжлох, бухимдуулах, сэтгэл санаагаар унагах гэх мэт харин бэлгийн хүчирхийлэлд хүч хэрэглэн бэлгийн харилцаанд орох эсвэл бэлгийн харилцаанд орохоос өөр аргагүй байдалд оруулах зэрэг хэлбэр байна. Хүчирхийллийн гэмт хэрэг нь олон нийтийн аюулгүй байдалд хор хүргэх хэмжээний ноцтой бөгөөд хохирогчдын сэтгэл санаа болон бие махбодын эрүүл мэндэд олон жилийн туршид муу уршигтай үр дагавар авчирдаг байна. Хүчирхийллийн эсрэг хуулиуд нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хариуцлага хүлээлгэхээс гадна хохирогчийн эрхийг хамгаалах үндсэн зорилготой байдаг бөгөөд хохирогчид тусламж үзүүлэх нийгмийн, сэтгэл зүйн, эмнэлгийн тусламж үйлчилгээ багтдаг. Хүчирхийллийн гэмт хэрэгт бие махбодын хүчирхийлэл, сэтгэл санааны болон эдийн засгийн хүчирхийллийг хамруулж авч үзсэн.

Судалгаанаас харахад эмэгтэйчүүд хүчирхийллийн хохирогч болох нь эрэгтэйчүүдээс даруй 2 дахин их, нийслэлд хамгийн их хүчирхийллийн гэмт хэрэг гардаг (43.9 хувь), гэр (32.5 хувь) болон сууцны тусдаа байшинд (36.0 хувь) амьдардаг хүн илүү энэ төрлийн гэмт хэрэгт өртөмтгий мөн 14-19 болон 30-39 насныхан хохирогч болох нь их байна.

Хүснэгт 20. Сүүлийн 3 жилд болон сүүлийн 12 сарын хугацаанд хүчирхийллийн улмаас хохирсон байдал, сонгосон үзүүлэлт, дүнд эзлэх хувиар


Үзүүлэлт		Хүчирхийллийн улмаас хохирсон байдал	
		Сүүлийн 3 жилд	Сүүлийн 12 сард
Хүйс	Эрэгтэй	36.4	31.3
	Эмэгтэй	63.6	68.7
Насны бүлэг	14-19	19.6	18.4
	20-24	7.9	7.7
	25-29	10.0	10.8
	30-34	15.5	15.0
	35-39	15.9	17.3
	40-44	10.1	11.2

Үзүүлэлт		Хүчирхийллийн улмаас хохирсон байдал	
		Сүүлийн 3 жилд	Сүүлийн 12 сард
Насны бүлэг	45-49	8.1	7.7
	50-54	4.6	3.7
	55-59	3.9	4.8
	60+	4.3	3.4
Үйлдлийн чадвар	Хүндрэлтэй	3.7	8.3
	Хүндрэлгүй	96.3	91.7
Байршил	Нийслэл	47.3	43.9
	Аймгийн төв	25.5	27.0
	Сумын төв	10.3	10.8
	Хөдөө	16.9	18.2
Бүс	Баруун бүс	10.5	12.2
	Хангайн бүс	16.3	16.8
	Төвийн бүс	13.9	12.3
	Зүүн бүс	12.0	14.7
	Нийслэл	47.3	43.9
Сууцны төрөл	Гэр	31.8	32.5
	Орон сууцны байшин	29.6	30.0
	Сууцны тусдаа байшин	37.2	36.0
	Нийтийн байр (ажилчдын, оюутны, бусад)	1.3	1.4
	Зориулалтын бус сууц	0.1	0.1

Хүчирхийллийн хохирогч болсон иргэдийн 78.8 хувь нь сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн гэж хариулсан ба дийлэнх нь ажлын байрны болон гэр бүлийн хүчирхийллийн улмаас үүссэн байна. Гэр бүл доторх сэтгэл санааны хүчирхийлэл нь эрх мэдлээ ашиглах болон дарангуйлагчийн сэтгэл санааны дарамт байдаг. Энэ нь амьдралын нөхцөл байдал, эдийн засгийн бэрхшээлтэй байдлаас ихэвчлэн үүдэлтэй. Өмнө дурдсанчлан 14-19 насны хүүхдүүдийн хүчирхийлэлд өртсөн хувь өндөр байгаа нь тэдэнд хэтэрхий өндөр шаардлага тавих, чөлөөтэй өсөж хөгжих боломжийг нь хязгаарлах, ёс зүй, хүмүүжилд нь хэт хөндлөнгөөс оролцох зэрэг сэтгэл санааны дарамт үзүүлсэнээс болсон байх талтай. Хүүхдэд үзүүлсэн сэтгэл санааны дарамтын хор уршиг их бөгөөд тэднийг нийгмийн харилцаанд оролцож чаддаггүй, нийгэмд дасан зохицох чадваргүй болох хүртэл нөлөөлөх муу талтайгаас гадна хүчирхийлэл үйлдэгддэг амьдралын хэв маяг нь давтагдан насанд хүрээд өөрийнхөө хүүхдэд хүчирхийлэл үйлдэх хэмжээнд хүрч болзошгүй юм.

Зураг 44.

Хүчирхийллийн улмаас хохирсон байдал, сүүлийн 12 сарын байдлаар, хүчирхийллийн хэлбэрээр, хувиар



Зураг 45.

Хүчирхийллийн улмаас хохирсон байдал, сүүлийн 12 сарын байдлаар, төрлөөр, хувиар




Мөн судалгааны үр дүнгээс гарсан нэг сонирхолтой баримт нь сэтгэл санааны хүчирхийлэл ажлын байранд их байдаг гэсэн хариулт бөгөөд хэт өндөр шаардлага тавих, ажлын их ачаалалтай байлгах, хэт хянах, айлган сүрдүүлэх, доромжлох, байнга шүүмжлэх нь хүний өөрийгөө үнэлэх үнэлэмжийг бууруулахад хүргэдэг бөгөөд сэтгэл санааны хүчирхийллийн нэг хэлбэр болдог байна.

Сэтгэл санааны хүчирхийллийн үр дагавар хүний нүдэнд харагдахгүй ч сэтгэцийн эрүүл мэндийн асуудлыг үүсгэдэг. Тодруулбал, хүний сэтгэл гутралын шалтгаан болдог. Байнгын сэтгэл санааны дарамт, айдас, гомдол, цөхрөл нь амьдралын утга учир зорилгоо алдах, өөрийгөө үнэлэх үнэлэмжийг бууруулахад хүргэдэг. Нөгөө талаар хүний сэтгэцийн эрүүл мэнд муудах нь алсдаа сэтгэлийн хямралд орох замаар бие махбодын эрүүл мэндэд нь асуудал үүсэх шалтгаан болж болно.

Судалгаагаар нийслэл хотод бүх төрлийн хүчирхийлэл хамгийн их үйлдэгдсэн бол аймгийн төв, хөдөөд гэр бүлийн хүчирхийлэл түлхүү үйлдэгдсэн байна.

Зураг 46.


Хүчирхийллийн улмаас хохирсон байдал, сүүлийн 12 сарын байдлаар, төрлөөр, байршлаар, хувиар



Гэр бүлийн хүчирхийлэл нь олон хүчин зүйлийн нөлөөгөөр үүсэх бөгөөд зөвхөн нэг хүн, нэг шалтгаанаас биш байдаг. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн гэж хариулсан иргэдээс хүчирхийлэл үйлдэгдэхэд хамгийн их нөлөөлсөн хүчин зүйлийг асууж тодруулахад гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн арван тохиолдол болгоны 3 нь согтуу, мансуурсан үед нь болсон байв. Харин санхүүгийн асуудлаас үүдэлтэй болон хардалтын шалтгаантай гэр бүлийн хүчирхийлэл арван тохиолдол бүрийн 2 нь байна.

Зураг 47.

Гэр бүлийн хүчирхийлэлд нөлөөлсөн хүчин зүйлс, сүүлийн 12 сарын байдлаар, хувиар



Хүчирхийллийн хохирогч болсон иргэдийн 32.3-33.3 хувь нь хөхрөх, хавдах гэх мэтээр бие махбодын гэмтэл авсан бол талаас их буюу 62.7 хувь нь сэтгэл санааны хямралд орсон, 45.2 хувь нь айж түгших эмгэг үүссэн гэж хариулжээ.

Зураг 48.


Хүчирхийллийн улмаас гэмтэл, хор уршиг учирсан байдал, сүүлийн 12 сарын байдлаар, гэмтэл, хор уршгийн төрлөөр, хувиар



Хүчирхийлэл үйлдэгчдийн 60.4 хувь нь эрэгтэйчүүд байв. Яагаад эрэгтэйчүүд хүчирхийлэл үйлдээд байгаа шалтгааныг судлах, цаашид тэднийг хүчирхийлэл үйлдэхгүй байх арга хэмжээг авах нь зөв алхам юм. Магадгүй тэдэнд хүүхэд насандаа гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн туршлага байх, бага насандаа сэтгэл зүйн гэмтэл авсан, өөрсдийгөө илүү хүчтэй, эрх мэдэлтэй гэж үзэж, хяналт тогтоохыг оролдох, мэдрэмж, уур бухимдал, стрессээ зохицуулах чадвар суугаагүй байх зэрэг үндсэн хүчин зүйлс байх боломжтой бөгөөд шалтгааныг судлан тодорхойлох хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь хүчирхийллийг бууруулахад ихээхэн хувь нэмэр оруулах болно.

Зураг 49.


Хүчирхийлэл үйлдсэн хүн, сүүлийн 12 сарын байдлаар, хүйсээр



Хамгийн сонирхолтой баримт нь хүчирхийллийн хохирогч болсон иргэдийн 79.9 хувь нь буюу арван хохирогч тутмын 8 нь тухайн хүчирхийллийн талаар эрх бүхий байгууллагад мэдэгдээгүй байна.

Зураг 50.


Хүчирхийллийн талаар эрх бүхий байгууллагад мэдэгдсэн эсэх, сүүлийн 12 сарын байдлаар, дүнд эзлэх хувиар



Хүчирхийллийн улмаас хохирогч болсон иргэдийн талаас их буюу 64.7 хувь нь хэргийг өөрөө шийдвэрлэсэн учраас эрх бүхий байгууллагад мэдэгдээгүй гэж хариулсан байна. Дээр дурдсанчлан хүчирхийллийн хохирогч асуудлыг хэрхэн өөрөө шийдвэрлэсэн байж болох нь сонирхолтой ойлгомжгүй хариулт хэвээр үлдсэн болно.

Зураг 51.

Хүчирхийллийн талаар эрх бүхий байгууллагад мэдэгдээгүй шалтгаан, сүүлийн 12 сарын байдлаар, хувиар



3.3.4

Ялгаварлан гадуурхах гэмт хэрэгт хохирсон байдал

Ялгаварлан гадуурхалт нь хүн эсвэл тодорхой бүлгийн хүмүүсийг арьс өнгө, үндэс угсаа, хүйс, нас, шашин шүтлэг, бэлгийн чиг хандлага, бие махбодын байдал, нийгмийн байр суурь болон бусад олон хүчин зүйлсийн үндсэн дээр ялгаатай харьцах үйлдлээр илэрдэг. Энэ нь тухайн хүнийг эсвэл бүлэг хүмүүсийг доромжлох, гадуурхах, эрхийг нь зөрчих, боломжийг нь хязгаарлах гэх мэт хэлбэрээр илэрч болно. Ялгаварлан гадуурхалт нь хувь хүн, олон нийтийн болон байгууллагын түвшинд гарах бөгөөд нийгмийн тэгш бус байдлыг бий болгохоос гадна хохирогчдын сэтгэл санааны, бие махбодын, нийгмийн эрүүл мэндэд олон сөрөг нөлөөтэй.


Монгол Улсын Үндсэн Хуулийн Арван дөрөвдүгээр зүйлд “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна. Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэж заасан. Мөн Эрүүгийн хуульд хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, эрүүл мэндийн нөхцөл байдлаар ялгаварлан гадуурхаж эрх, эрх чөлөөг нь хязгаарласан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр тус тус зохицуулсан байдаг. Олон улсын түвшинд ялгаварлан гадуурхалтын эсрэг тэмцэх нь хүний эрхийг хамгаалах, нийгэмд тэгш байдал, шударга ёс тогтоох гол зорилтуудын нэг бөгөөд энэ чиглэлд олон улсын байгууллагууд, нийгмийн хөдөлгөөнүүд, төр засгийн байгууллагууд

тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлсээр байна. Тухайлбал, Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1948), Ялгаварлан гадуурхалтын бүх хэлбэрийг устгах тухай конвенц (1965), Эмэгтэйчүүдийн эсрэг бүх хэлбэрийн ялгаварлан гадуурхалтыг устгах тухай конвенц (1979) зэргийг батлан тунхаглаж дэлхий даяар шударга ёс, тэгш байдалд хүрэхийг зорьж байна.

Бид энэ хэсэгт сүүлийн 12 сарын хугацаанд ялгаварлан гадуурхалтын эсрэг гэмт хэрэгт хохирсон 14 ба түүнээс дээш насны хүн амын шинж байдал, шалтгаан нөхцлийн талаар дэлгэрэнгүй танилцуулахыг зорьсон болно.

Ялгаварлан гадуурхах гэмт хэрэгт хохирсон иргэдийн 53.9 хувь сайн таньдаг хүндээ, 20.7 хувь зүс таних төдий хүнд, 23.6 хувь танихгүй хүнд ялгаварлан гадуурхагдсан байгаа бөгөөд ялгаварлан гадуурхах гэмт хэрэг үйлдсэн иргэдийн 30.1 хувь бүлэглэж үйлдсэн байна.

Зураг 52.

Ялгаварлан гадуурхсан хүнийг таньдаг эсэх, дүнд эзлэх хувиар

Судалгаанаас харахад ялгаварлан гадуурхах гэмт хэргийн шинж хүчирхийллийн гэмт хэргийн шинж байдалтай ижил хандлагатай буюу эмэгтэйчүүд ялгаварлан гадуурхалтад өртөх нь эрэгтэйчүүдээс их, нийслэлд хамгийн их ялгаварлан гадуурхалтын гэмт хэрэг гардаг, мөн 14-19 болон 30-39 насныхан энэ хэргийн хохирогч болох нь их байна.

Хүснэгт 21.

Сүүлийн 3 жилд болон сүүлийн 12 сарын хугацаанд ялгаварлан гадуурхах гэмт хэрэгт хохирсон байдал, сонгосон үзүүлэлт, хувиар

Үзүүлэлт		Ялгаварлан гадуурхалтын гэмт хэрэгт хохирсон байдал	
		Сүүлийн 3 жилд	Сүүлийн 12 сард
Хүйс	Эрэгтэй	45.0	38.9
	Эмэгтэй	55.0	61.1
Насны бүлэг	14-19	28.1	27.0
	20-24	8.2	10.3
	25-29	10.3	8.6

Үзүүлэлт		Ялгаварлан гадуурхалтын гэмт хэрэгт хохирсон байдал	
		Сүүлийн 3 жилд	Сүүлийн 12 сард
Насны бүлэг	30-34	11.7	11.5
	35-39	10.4	14.6
	40-44	8.5	8.0
	45-49	6.7	6.1
	50-54	6.0	5.1
	55-59	3.5	4.0
	60+	6.6	4.8
Үйлдлийн чадвар	Хүндрэлтэй	9.6	6.3
	Хүндрэлгүй	90.4	93.7
Байршил	Нийслэл	38.9	47.1
	Аймгийн төв	25.9	23.2
	Сумын төв	14.7	9.5
	Хөдөө	20.5	20.3
Бүс	Баруун бүс	11.2	11.4
	Хангайн бүс	16.6	17.1
	Төвийн бүс	24.4	12.2
	Зүүн бүс	8.9	12.3
	Нийслэл	38.9	47.1

Сүүлийн 12 сарын хугацаанд ялгаварлан гадуурхах гэмт хэрэгт хохирсон иргэдийн 29.8 хувь ажлын байрандаа, 24.2 хувь сургууль дээрээ, 11.2 хувь гудамж талбайд өртсөн байна.

Зураг 53.


Ялгаварлан гадуурхах гэмт хэрэг болсон газрын байршил, сүүлийн 12 сарын байдлаар, дүнд эзлэх хувиар



Зураг 54-т сүүлийн 12 сард ялгаварлан гадуурхах гэмт хэрэг хамгийн их үйлдэгдсэн газрын байршлыг үйлдлийн чадварын хүндрэлтэй эсэхээр нь харууллаа. Ажлын байранд үйлдлийн чадварын хүндрэлгүй иргэдийн дийлэнх буюу 97.6 хувь ялгаварлан гадуурхах гэмт хэрэгт хохирсон бол амралт, сувилал, жуулчны баазад үйлдлийн чадварын хүндрэлтэй иргэдийн 60.7 хувь ялгаварлан гадуурхалтад өртсөн байна.


Зураг 54.

Ялгаварлан гадуурхах гэмт хэрэг болсон газрын байршил, үйлдлийн чадварын хүндрэлтэй эсэх, сүүлийн 12 сарын байдлаар, хувиар




Зураг 55.

Ялгаварлан гадуурхах гэмт хэргийн хохирогч болсон иргэд, ялгаварлан гадуурхалтын төрөл, сүүлийн 12 сарын байдлаар, хувиар



Зураг 56.


Ялгаварлан гадуурхах гэмт хэргийн хохирогч болсон иргэд, ялгаварлан гадуурхалтын зарим төрөл, бүс, сүүлийн 12 сарын байдлаар, дүнд эзлэх хувиар



Сүүлийн 12 сарын хугацаанд ялгаварлан гадуурхах гэмт хэргийн хохирогч болсон иргэдийн 34.9 хувь үзэл бодлын ялгаварлан гадуурхалтад өртсөн бол 31.0 хувь гадна төрхөөрөө, 17.1 хувь амьжиргааны түвшнээрээ ялгаварлан гадуурхах гэмт хэрэгт хохирсон байна. Мөн түүнчлэн гадна төрхөөрөө ялгаварлан гадуурхалтад өртсөн иргэдийн ихэнх буюу 61.1 хувь нийслэлд байгаа бол нутаг усаар ялгаварлан гадуурхах гэмт хэрэгт хохирсон иргэдийн 36.6 хувь Хангайн бүсэд амьдардаг иргэд байв.

Зураг 57.

Ялгаварлан гадуурхах гэмт хэргийн талаар эрх бүхий байгууллагад мэдэгдсэн эсэх, сүүлийн 12 сарын байдлаар, хувиар



Зураг 58.

Ялгаварлан гадуурхах гэмт хэргийн талаар эрх бүхий байгууллагад мэдэгдээгүй шалтгаан, сүүлийн 12 сарын байдлаар, хувиар



Ялгаварлан гадуурхах гэмт хэрэгт хохирсон иргэдийн 4.6 хувь энэ төрлийн гэмт хэргийн талаар эрх бүхий байгууллагад мэдээлэл өгсөн бол 94.4 хувь нь эрх бүхий байгууллагад мэдэгдээгүй байна. Ялгаварлан гадуурхах гэмт хэргийн талаар эрх бүхий байгууллагад мэдэгдээгүй хамгийн гол шалтгаан нь өөрөө шийдвэрлэсэн (62.2 хувь) гэсэн хариулт бөгөөд өөрөө хэрхэн шийдвэрлэсэн нь асуулт хэвээр үлдэв.

3.4


Тогтвортой хөгжлийн зорилго

Энэхүү судалгааг зохион байгуулан явуулах нэг чухал хэрэгцээ шаардлага нь “Тогтвортой хөгжлийн зорилго”-ын зарим шалгуур үзүүлэлтийг тооцон гаргах явдал бөгөөд энэ хэсэгт судалгаанаас тооцон гаргасан ТХЗ-ын үр дүнг танилцуулж байна.

Зорилт 11.7-д “2030 он гэхэд хүн бүрийг, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүд, өндөр настнууд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг аюулгүй, бүх талын оролцоог хангасан, хүртээмжтэй, ногоон болон нийтийн эзэмшлийн талбайгаар хангах” гэж заасан бөгөөд 11.7.2 дах шалгуур үзүүлэлт нь сүүлийн 12 сард бие махбодын хохирол амссан, бэлгийн дарамтад орсон хүн амын эзлэх хувийг, хүйсээр, насны бүлгээр, хөгжлийн бэрхшээлтэй хүн амаар, хэрэг гарсан байршлаар гаргахаар тусгасан байдаг. Энэхүү судалгаанаас дээрх үзүүлэлтийг улсын дундаж болон хүйсээр тооцоход 14 ба түүнээс дээш насны нийт хүн амын 0.84 хувь нь бие махбодын хүчирхийлэл болон бэлгийн дарамтын аль нэгд өртсөн байна. Харин 14 ба түүнээс дээш насны эрэгтэйчүүдийн 0.59 хувь, эмэгтэйчүүдийн 1.03 хувь нь бие махбодын хүчирхийлэл болон бэлгийн дарамтын аль нэгд өртсөн байна. Бие махбодын хүчирхийлэлд өртсөн эрэгтэй, эмэгтэйчүүдийн тохиолдол ойролцоо байгаа бол бэлгийн дарамтад эмэгтэйчүүд илүү өртсөн байна.

Зураг 59.


Сүүлийн 12 сард бие махбодын хохирол амссан, бэлгийн дарамтад орсон хүн амын эзлэх хувь, хүйсээр



Зорилт 16.1-д хүчирхийллийн бүх хэлбэр, нас баралтын холбогдолтой түвшнийг үлэмж хэмжээгээр бууруулах гэж заасан байдаг бөгөөд 16.1.3 дах шалгуур үзүүлэлт нь сүүлийн 12 сарын дотор бие махбод, сэтгэл санааны, бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүн амын эзлэх хувиар илэрхийлэгдэнэ. Эдгээр үзүүлэлтийг хэмжихдээ олон улсад захиргааны мэдээллээс илүү судалгааны дүнд үндэслэн тооцдог байна. Энэхүү судалгааны үр дүнгээр нийт 14 ба түүнээс дээш насны хүн амын 6 хувь нь бие бялдар, сэтгэл санааны, бэлгийн хүчирхийллийн аль нэгэнд өртсөн бол эмэгтэйчүүдийн 6.9 хувь, эрэгтэйчүүдийн 4.9 хувь нь энэ төрлийн хүчирхийлэлд өртсөн байна.

Зураг 60.


Сүүлийн 12 сарын хугацаанд бие махбод, сэтгэл санааны, бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүн амын эзлэх хувь, хүйсээр



Хүчирхийлэл, нас баралтын түвшний талаарх ойлголтын нэг хэмжүүр нь хүмүүс өдөр тутмын амьдралдаа хэрхэн аюулгүй байдлаа мэдэрч байгаагаар илэрхийлэгдэнэ. ТХЗ-ын 16.1.4-р шалгуур үзүүлэлт нь амьдардаг орчиндоо ганцаараа алхахад аюулгүй байдлыг мэдэрдэг хүн амын эзлэх хувь юм. Хүмүүсийн аюулгүй байдлын талаарх ойлголт янз бүрийн хүчин зүйлээс хамаарч тодорхойлогддог тул энэ нь дэлхийн улс орнуудад өөр өөр хандлагатай байдаг. Дэлхийн 114 улсаас авсан судалгааны мэдээлэлд үндэслэн гаргасан үр дүнгээр Дэлхийн хүн амын 69 орчим хувь нь амьдардаг орчиндоо ганцаараа алхаж байхдаа аюулгүй байдлыг мэдэрдэг бөгөөд эрэгтэйчүүдийн 71 хувь, эмэгтэйчүүдийн 61 хувь нь аюулгүй байдлыг мэдэрдэг байна. Аюулгүй байдлын талаарх ойлголтын ялгаатай байдал бүс нутгуудад ажиглагдаж байна. Латин Америк, Карибын тэнгисийн орнуудад судалгаанд оролцогчдын аюулгүй байдал хамгийн бага байдаг бол Ази болон Европ, Хойд Америкт судалгаанд оролцогчид харьцангуй аюулгүй санагддаг гэж хариулсан байна. Харин манай улсын хувьд хүн амын тал хувь нь аюулгүй байдлыг мэдэрдэг бол эрэгтэйчүүдийн 52 хувь, эмэгтэйчүүдийн 48 хувь нь амьдардаг орчиндоо ганцаараа алхахад аюулгүй байдлыг мэдэрдэг байна.

Зураг 61.

Амьдардаг орчиндоо ганцаараа алхахад аюулгүй байдлыг мэдэрдэг хүн амын эзлэх хувь, хүйсээр, 2016-2023 оноор




Зорилт 16.2-т Хүүхэдтэй зэрлэгээр харьцах, тэднийг мөлжих, наймаалах, тамлан зовоох, хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг зогсоох устгах гэж заасан бөгөөд шалгуур үзүүлэлт 16.2.3 нь 18 хүртэлх насандаа бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан 18-29 насны эрэгтэй, эмэгтэйчүүдийн эзлэх хувиар илэрхийлэгдэнэ.

Бэлгийн хүчирхийлэл бол хүүхдийн эрхийн ноцтой зөрчлийн нэг хэлбэр бөгөөд хүүхдийн хүчирхийллийн олон хэлбэрээс хамгаалахад чиглэсэн олон улсын эрх зүйн тусгай баримт бичгийн чухал асуудал юм. Бэлгийн хүчирхийлэлд бүх насны хүүхдүүд хохирсон байдаг ч ялангуяа өсвөр насны охид илүү өртөмтгий байдаг. Дэлхийн 50 гаруй улс 2014-2023 он хүртэлх хугацаанд охидын бэлгийн хүчирхийллийн талаар харьцуулж болохуйц тоо мэдээлэлтэй болжээ. Улс орнуудын үр дүнг харьцуулан харвал хүүхэд насандаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн хувь харилцан адилгүй байх бөгөөд манай улсын 18-29 насны эмэгтэйчүүдийн 3.0 хувь нь хүүхэд насандаа бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан гэх судалгааны дүн гарсан байна.

Зураг 62.


18 хүртэлх насандаа бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан 18-29 насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь, улсуудаар, 2014-2023



Эх үүсвэр: <https://www.undp.org/sites/g/files/zskgke326/files/2023-09/undp-unodc-unhchr-global-progress-report-on-sdg-16-indicators.pdf>

4

ХАВСРАЛТ



4.1

Статистик
хүснэгт

Хүснэгт 1.1 Өрхийн шинж байдал

Судалгаанд хамрагдсан өрхийн тоо, дүнд эзлэх хувь, сонгосон үзүүлэлтээр, 2023он

	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь
Нийт	7,673	100.0
Бүс		
Баруун бүс	1,181	15.4
Хангайн бүс	1,456	19.0
